

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |  |  |      |
|------|--|--|------|
| 366. | Конвенц соёрхон батлах тухай           |  | 1265 |
| 367. | Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай |  | 1266 |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 368. | Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай | Дугаар 38 | 1266 |
|------|---|-----------|------|

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |      |  |            |      |
|------|--|------------|------|
| 369. | Журам батлах тухай                               | Дугаар 184 | 1268 |
| 370. | Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай | Дугаар 189 | 1281 |
| 371. | Хөтөлбөр батлах тухай                            | Дугаар 209 | 1282 |

**МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

- |      |   |  |      |
|------|---|--|------|
| 372. | Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1907 оны конвенц  |  | 1292 |
| 373. | Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн Зээлийн хэлэлцээр |  | 1316 |

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны 10 дугаар  
сарын 11-ний өдөр

Улаанбаатар  
хот

**КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1907 оны конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар  
сарын 11-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 04 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

#### **Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай**

Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн хэмээн тодорхойлсон Үндсэн хуулийн үзэл санаа алдагдаж, төрийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулан хувийн ашиг хонжоо олоход ашигладаг, ашиг сонирхлоор холбогдсон этгээддээ давуу байдал олгодог, иргэн, хуулийн этгээд нь хууль ёсны эрх, ашгаа хамгаалахаас илүүтэй хууль бус давуу байдлыг олж авах эрмэлзэлд хөтлөгдөх болсон зэрэг үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулах нөхцөл байдал бодитоор орших болсныг онцлон,

Авлига, хээл хахуультай тэмцэх үйл ажиллагаанд бүх нийтээр анхаарч нэгдэх, аливаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэж, шийдвэрлүүлэх, хууль бус хүсэлт, шаардлагыг үл зөвшөөрөх ухамсар, соёл, хандлагыг нийгмийн бүхий л түвшинд дэмжин төлөвшүүлэхэд чиглэсэн үндэсний бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага нэн чухал байгааг зөвшөөрч,

Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг илрүүлж илчилсэн мэдээлэгчийг урамшуулах, хамгаалах, авлига, албан тушаалын гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэрчийг хамгаалах зэрэг асуудалд тусгайлан анхаарч, хууль, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох ёстойг тэмдэглэн,



Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. 2018-2019 оныг “Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил” болгон зарласугай.

2. “Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил”-ийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газарт зөвлөсүгэй:

а) Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг судлан сайжруулах, авлигыг илрүүлж илчилсэн иргэнийг урамшуулах, хамгаалах, авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэрчийг хамгаалах асуудлын хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилт, хэрэгцээ шаардлагыг үнэлэн судалж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээг цаг алдалгүй авах;

б) Эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлын хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэргийн гэрч, мэдээлэгчийг аюулгүй байдлын болон амьдрах нөхцөл, эдийн засгийн баталгаагаар хангах асуудлыг шийдвэрлэх;

в) Шүүх ажиллагааны аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах асуудлын хүрээнд төрийн байгууллагуудын чиг үүрэг, тогтолцоог улам боловсронгуй болгох.

3. Авлигын хор уршиг, хохирлыг ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж, түгээн дэлгэрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай.

4. Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жилийн хүрээнд бүх нийтээр авлигыг үл тэвчин, тухай бүр илчилж, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэхийн төлөө нягт хамтарч, нэгнээ дэмжин ажиллахыг ард иргэддээ уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”-ыг 2 дугаар хавсралт, “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 233 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД**

**Ц.ЦОГЗОЛМАА**

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.4-т заасан төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын байдлыг мөн хуулийн 26.1-д заасны дагуу гурван жил тутам нягтлан үзэж, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Соёлын биет бус өвийн үзлэг хийхэд бэлтгэх, зохион байгуулах, тайлагнахад энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Соёлын биет бус өвийн үзлэг хийх ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах, зохион байгуулах, тайлагнах үүргийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

1.4. Соёлын биет бус өвийн үзлэгийг Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.3-т заасны дагуу бүсчлэн зохион байгуулна.

1.5. Соёлын биет бус өвийн үзлэгийг хуанлийн жилд багтаан зохион байгуулна.

#### Хоёр. Үзлэг хийхэд бэлтгэх

2.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга соёлын биет бус өвийн үзлэг хийх ажлын удирдамж болон үзлэгийн ажлыг энэхүү журмын 1.4-т заасан бүс нутагт хэрэгжүүлэх ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийн бүрэлдэхүүнийг батална.

2.2. Ажлын хэсэгт төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, үзлэгт хамрагдах орон нутгийн төлөөллийг оролцуулах бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, 5-аас дээшгүй гишүүнээс бүрдэнэ.

2.3. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчийн тоо хэмжээ, газар нутгийн цар хүрээнээс хамаарч энэхүү журмын 1.4-т заасан бүс нутагт хэд хэдэн Ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

2.4. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн бүс нутагт уламжлан хадгалагдсан соёлын биет бус өвийн бүртгэлийг бэлтгэж, Ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

2.5. Бүх шатны Засаг дарга Ажлын хэсэгт шаардлагатай дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

2.6. Соёлын биет бус өвийн үзлэг хийхэд шаардагдах зардлыг Соёл, урлагийг дэмжих санд хуваарилагдсан хөрөнгөөс санхүүжүүлнэ.

#### Гурав. Үзлэгийн ажлыг зохион байгуулах

3.1. Ажлын хэсэг соёлын биет бус өвийн үзлэгийн ажлыг холбогдох хууль, энэхүү журамд заасны дагуу үнэн зөв, шуурхай, чанартай зохион байгуулна.



### 3.2. Ажлын хэсэг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг тандан судлах;

3.2.2. соёлын биет бус өвийг сурвалжлан олж, судлах;

3.2.3. соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч болон орон нутгийн ард иргэдтэй уулзаж мэдээлэл цуглуулах;

3.2.4. соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд эерэг, сөрөг нөлөөлж байгаа хүчин зүйлийг илрүүлж, тогтоох;

3.2.5. соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн тоо болон газар нутгийн тархалтыг тогтоох;

3.2.6. соёлын биет бус өвийг хамгаалах чиглэлээр тухайн орон нутагт зохион байгуулагдсан арга хэмжээний талаарх мэдээллийг цуглуулах;

3.2.7. соёлын биет бус өв тус бүрийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;

3.2.8. соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах;

3.2.9. соёлын биет бус өвийн үзлэгийн тайланг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх.

3.3. Ажлын хэсгийн дарга Ажлын хэсгийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, үзлэгийн ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг батлан, гишүүдийн хариуцах ажил үүргийг тогтооно.

3.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга ажлын хэсгийн үйл ажиллагааг баримтжуулах, холбогдох баримт бичгийг хадгалах, ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

3.5. Ажлын хэсэг соёлын биет бус өвийн үзлэгийн үеэр олж авсан хувь хүн, албан байгууллагын нууцыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу чандлан нууцална.

3.6. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан гишүүдэд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өөрийн төсвийн багцаас мөнгөн урамшуулал олгоно.



### Дөрөв. Үзлэгийн ажлын дүнг тайлагнах

4.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Ажлын хэсгээс ирүүлсэн тайланг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний саналын хамт дараа оны эхний улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

4.2. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага соёлын биет бус өвийн үзлэгийн ажилд холбогдох тайлан, бусад мэдээллийг дэвтэрлэн Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өгч хадгалуулна.

### Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

## ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТООЛЛОГО ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь түүх, соёлын үл хөдлөх дурсгал (цаашид “үл хөдлөх дурсгал” гэх)-ын эх төрх, бүрэн бүтэн байдлыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1-д заасны дагуу таван жил тутам нягтлан шалгаж, хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Үл хөдлөх дурсгалын тооллогын комисс байгуулах, тооллого хийхэд бэлтгэх, зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Тооллогын ажилд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй үл хөдлөх дурсгалын жагсаалт бүхий тооллогын дэвтрийг ашиглана.

### Хоёр. Тооллогын комисс байгуулах

2.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тооллогын ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий Улсын комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг тухайн жилийн 2 дугаар сарын 15-ны дотор баталж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.



2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тооллогын ажлыг зохион байгуулах үүрэг бүхий салбар комиссын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг тухайн жилийн 3 дугаар сарын 15-ны дотор батална.

2.3. Комиссын бүрэлдэхүүн нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэдийн төлөөллийг оролцуулна. Комиссын бүрэлдэхүүн нь сондгой тооны төлөөллөөс бүрдэнэ.

2.4. Улсын комиссын орон нутагт ажиллахад шаардагдах зардлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, салбар комиссын орон нутагт ажиллахад шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус хариуцна.

2.5. Сум, дүүргийн Засаг дарга, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хил хамгаалах байгууллага, түүний харъяа анги, нэгтгэлүүд нь улсын болон салбар комиссын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

#### Гурав. Тооллогод бэлтгэх

3.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үл хөдлөх дурсгалын тооллогын ажлын бэлтгэлийг хангах талаар дараах ажлыг зохион байгуулна:

3.1.1. тооллого явуулах талаар сургалт зохион байгуулах;

3.1.2. тооллогын ажилд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг холбогдох байгууллагад хуваарилах;

3.1.3. тооллогын ажлыг зохион байгуулах талаарх мэдээллийг онцгой байдал, хил хамгаалах болон мэргэжлийн хяналтын байгууллага, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд мэдэгдэх;

3.1.4. тооллогын ажилд ашиглах тооллогын дэвтрийг хэвлэж бэлтгэх.

3.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга салбар комиссын орон нутагт ажиллахад ашиглах туулах чадвар сайтай, техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан тээврийн хэрэгслийг бэлтгэнэ.

#### Дөрөв. Тооллогын ажлыг зохион байгуулах

4.1. Улсын комиссын дарга тооллогын дэвтэрт гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан салбар комисст хүлээлгэж өгнө.



4.2. Салбар комиссын дарга тооллогын ажлыг орон нутагт зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, гишүүдийн ажил үүргийн хуваарийг энэхүү журмын 2.1-д заасан удирдамжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

4.3. Салбар комисс улсын хилийн бүс, улсын тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах бол холбогдох зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авна.

4.4. Салбар комисс тооллогын ажлыг холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд заасны дагуу үнэн зөв, шуурхай, чанартай зохион байгуулна. Салбар комисс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. тооллогын дэвтэрт бичигдсэн үл хөдлөх дурсгалыг тооллогод бүрэн хамруулах;

4.4.2. үл хөдлөх дурсгалын гэрэл зургийг харьцуулах хэмжээстэй авах, дүрс бичлэг хийж байршлыг тогтоох;

4.4.3. шинээр илэрсэн дурсгалыг зохих журмын дагуу бүртгэж, тооллогод хамруулах;

4.4.4. үл хөдлөх дурсгалын талаар тооллогын дэвтэрт буруу бичигдсэн тохиолдолд бичвэрийн шалтгааныг судлан тодруулж, тэмдэглэл бичих;

4.4.5. тооллогын ажлын явцын мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг дарга болон улсын комисст 30 хоног тутам мэдээлэх;

4.4.6. хууль бус үйл ажиллагаанд өртсөн үл хөдлөх дурсгалын талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад хүргүүлэх.

4.5. Салбар комисс тооллогын явцад галын аюулгүй байдлын хууль тогтоомжийг чанд мөрдөж, аливаа эрсдэлээс өөрсдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалж ажиллана.

4.6. Салбар комиссын дарга тооллогын явцад тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийлгэнэ.

4.7. Улсын болон салбар комиссын бүрэлдэхүүнд ажилласан гишүүдэд комиссыг томилсон соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн төсвийн зардлаас мөнгөн урамшуулал олгоно.



### Тав. Тооллогын ажлын дүнг тайлагнах

5.1. Салбар комисс тооллогын ажлын тайланг мөн оны 11 дүгээр сарын 1-ний дотор эцэслэж, холбогдох баримт бичгийн хамт аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулна.

5.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тооллогын ажлын тайлантай танилцаад мөн оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор зохих санал дүгнэлтийн хамт Улсын комисст хүргүүлнэ.

5.3. Улсын комисс аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн тайланг нэгтгэж дүнг мөн оны 12 дугаар сарын 15-ны дотор соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулна.

5.4. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тооллогын ажлын нэгдсэн дүнг тухайн жилд багтаан Засгийн газарт танилцуулна.

5.5. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн тайлан, холбогдох бусад баримт бичгийг Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өгч хадгалуулна.

### Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр  
тогтоолын 3 дугаар хавсралт

### ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ТООЛЛОГО ХИЙХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл (цаашид “дурсгалт зүйл” гэх)-ийн эх төрх, бүрэн бүтэн байдал, бүтэц, шинж чанар, тоо хэмжээг дөрвөн жил тутам нягтлан шалгаж, хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн дурсгалт зүйлийн тооллогын ажлыг бэлтгэх, зохион байгуулах, тайлагнахад энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй шашны, олон нийтийн болон хувийн өмчийн дурсгалт зүйлийг өмчлөгчийн зөвшөөрлөөр энэхүү журамд заасны дагуу тооллогод хамруулж болно.

1.4. Тооллогын ажлыг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн болон байгууллагын эд хөрөнгийн бүртгэлд үндэслэн явуулна. Шаардлагатай тохиолдолд дурсгалт зүйлийн хувийн хэрэг, карт, бусад баримт бичгийг ашиглаж болно.

#### Хоёр. Тооллогын комисс

2.1. Тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах үүрэг бүхий Улсын комиссын бүрэлдэхүүнийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Улсын комиссын дарга нь Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга байна.

2.2. Тооллогын ажлыг аж ахуйн нэгж, байгууллага, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүргийг салбар комисс хэрэгжүүлнэ. Засгийн газрын гишүүн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн өмчийн музей, номын сан, эрдэм шинжилгээний байгууллага болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад хадгалагдаж байгаа дурсгалт зүйлд тооллого хийх салбар комиссын бүрэлдэхүүнийг, аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн өмчийн музей, номын сан, орон нутаг судлах танхим болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад хадгалагдаж байгаа дурсгалт зүйлд тооллого хийх салбар комиссын бүрэлдэхүүнийг тус тус батална.

2.3. Энэхүү журмын 1.3-т заасан дурсгалт зүйлийн тооллого хийх тусгай комиссын бүрэлдэхүүнийг Улсын комиссын саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.4. Улсын болон салбар комиссын бүрэлдэхүүн нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөлөл, тооллогод хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг оролцуулсан сондгой тоотой байна.

2.5. Энэхүү журмыг зөрчиж, хариуцлага хүлээж байсан этгээдийг улсын болон салбар комиссын бүрэлдэхүүнд ажиллуулахгүй.

2.6. Тооллогын комисс тооллогын ажлыг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, энэхүү журамд нийцүүлэн үнэн зөв, шуурхай, чанартай зохион байгуулна.

2.7. Улсын комисс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



2.7.1. тооллогын ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах;  
2.7.2. тооллогын ажлын явцын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

2.7.3. салбар комиссын үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн заавар, зөвлөгөө өгөх;

2.7.4. салбар комиссоос тооллогын дэвтэрт тусгахаар ирүүлсэн саналыг тухай бүр хянаж, шийдвэрлэх;

2.7.5. тооллогын дэвтэр хөтлөлт, “Тоолов (...он)” тэмдгийн ашиглалтын байдалд хяналт тавих;

2.7.6. тооллогын ажлын дүн мэдээг нэгтгэж, тайлагнах;  
2.7.7. эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.

## 2.8. Салбар комисс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.8.1. тооллогын ажлыг аж ахуйн нэгж, байгууллага, орон нутгийн хэмжээнд төлөвлөж, зохион байгуулах;

2.8.2. шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эрдэмтэн, судлаачдыг оролцуулж тусламж авах;

2.8.3. комиссын хурлаар зөвшөөрсөн тохиолдолд тооллогын ажлын явцын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

2.8.4. тооллогын дэвтэрт бичигдсэн дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ, жин, хадгалалтын байдлыг илэрхийлсэн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Улсын комисст хүргүүлж, шийдвэрлүүлэх;

2.8.5. дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлын талаар танилцуулга бэлтгэх;

2.8.6. дутсан, солигдсон дурсгалт зүйлийн талаарх мэдээллийг бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг дарга, цагдаагийн байгууллагад хүргүүлэх;

2.8.7. тооллогын ажлын тайланг бэлтгэж, дэвтэрлэн үдэх;

2.8.8. тооллогын ажлын дүн мэдээг тогтоосон хугацаанд тайлагнах;

2.8.9. эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.

2.9. Тооллогын комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шийдвэр тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд түүнд комиссын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.10. Улсын болон салбар комиссын бүрэлдэхүүнд ажилласан гишүүдэд комиссыг томилсон Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн төсвийн багцаас мөнгөн урамшуулал олгоно.

Гурав. Тооллогын дэвтэр, “Тоолов (...он)” тэмдэг

3.1. Тооллогын ажилд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй дурсгалт зүйлийн жагсаалтыг аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр хэвлэж, дэвтэрлэсэн тооллогын дэвтрийг ашиглана. Тооллогын дэвтэр нь дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ жин, хадгалалтын байдал, тайлбар гэсэн асуулга бүхий баганатай байна.

3.2. Улсын комисс шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 3.1-д заасан тооллогын дэвтрийн асуулга дээр нэмж нэгээс илүүгүй асуулга бүхий багана нэмж болно.

3.3. Тооллогын дэвтэрт орсон дурсгалт зүйлийн жагсаалт, холбогдох мэдээлэл үнэн, зөв эсэхэд Улсын комисс хяналт тавина.

3.4. Улсын комиссын дарга тооллогын дэвтэр, “Тоолов (...он)” тэмдгийг салбар комисст хүлээлгэн өгнө.

3.5. Тооллогын дэвтэр нь дурсгалт зүйлийн жагсаалтыг А4 хэмжээтэй цаасны нэг талд хэвлэсэн, 250-аас илүүгүй хуудастай байна. Тооллогын дэвтрийг Улсын комиссын дарга гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

3.6. Салбар комисс дурсгалт зүйлийг тооллогод хамруулсныг гэрчлэх “Тоолов (...он)” гэсэн бичвэр бүхий тэмдгийг ашиглана. Тэмдгийн бичвэрийг засварлах, гэмтээхийг хориглоно.

3.7. “Тоолов (...он)” тэмдгийг ашиглах боломжгүй болсон бол энэ тухай Улсын комисст мэдэгдэж, шинээр хийлгэн ашиглаж болно. Энэ тохиолдолд ашиглах боломжгүй болсон тэмдгийг Улсын комисст хүлээлгэн өгнө.



3.8. Тооллогын дэвтэр болон “Тоолов (...он)” тэмдгийг тооллого хийж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас өөр газарт хадгалахыг хориглоно.

#### Дөрөв. Тооллогын ажилд бэлтгэх

4.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн жилд зохион байгуулах дурсгалт зүйлийн тооллого хийх тухай шийдвэрийн төсөл, удирдамж, төлөвлөгөөний төслийг боловсруулж соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.2. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дурсгалт зүйлийн тооллого хийх тухай шийдвэр, Улсын комиссын бүрэлдэхүүн, удирдамж, төлөвлөгөөг баталж, Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.3. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дурсгалт зүйлийн тооллого хийх тухай шийдвэр, удирдамжийг холбогдох этгээдэд хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.4. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн жилд зохион байгуулах тооллогын ажилд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, нэгдсэн сургалт зохион байгуулах, тооллогын дэвтэр хэвлүүлэх, “Тоолов (...он)” тэмдэг хийлгэх, гарын авлага, сургалтын материал бэлтгэх ажлыг хариуцан зохион байгуулна.

4.5. Дурсгалт зүйлийн тооллого хийхэд шаардагдах зардлыг Соёл, урлагийг дэмжих санд хуваарилагдсан хөрөнгөөс санхүүжүүлнэ.

#### Тав. Тооллогын ажлыг зохион байгуулах

5.1. Салбар комиссын дарга тооллогын ажлыг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг энэхүү журмын 4.2-т заасан удирдамжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

5.2. Тооллогод хамрагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага тооллогын ажил эхлэхээс өмнө дурсгалт зүйлийн бүртгэлийн дэвтэр, эд хөрөнгийн бүртгэл болон тооллогын ажилд шаардлагатай холбогдох бусад баримт бичгийг салбар комисст хүлээлгэн өгнө.

5.3. Салбар комисс холбогдох хууль, тогтоомжийн дагуу улсын хилээр гаргаснаас бусад дурсгалт зүйлийг тооллогод бүрэн хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.4. Тооллогын ажлыг салбар комиссын гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэйгээр зохион байгуулна.

5.5. Салбар комисс дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ жин, хадгалалтын байдлыг тооллогын дэвтрийн бичвэртэй харгалзуулан нэг бүрчлэн шалгаж, бичвэр тус бүрийн зүүн доод буланд “√” гэж тэмдэглээд “тайлбар” баганын харгалзах эгнээнд “Тоолов (...он)” тэмдэг дарна.

5.6. Дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ, жин, хадгалалтын байдлыг илэрхийлсэн бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан, эсхүл дурсгалт зүйл дутсан, солигдсон, хулгайд алдагдсан бол тооллогын дэвтэрт “√” тэмдэглэгээ хийхгүй бөгөөд “Тоолов (...он)” тэмдгийг дарахгүй.

5.7. Салбар комисс энэхүү журмын 5.6-д заасан бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, холбогдох баримт бичгийн хамт Улсын комисст хүргүүлнэ.

5.8. Салбар комисс нь энэхүү журмын 5.6-д заасан бичвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Улсын комиссоос ирүүлсэн шийдвэрийг үндэслэн тооллогын дэвтрийн “тайлбар” баганын харгалзах эгнээнд зохих нэмэлт, өөрчлөлтийг гараар бичиж “Тоолов (...он)” тэмдэг дарна. Энэ тохиолдолд өөрчилсөн бичвэрийн зүүн доод буланд “√” гэж тэмдэглэхгүй.

5.9. Салбар комисс тооллого хийхдээ соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим бүртгэлийн программыг ашиглана. Энэхүү журмын 5.8-д заасан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр бүртгэлийн программд нэмж оруулна.

5.10. Салбар комисс тооллогод хамрагдаж байгаа дурсгалт зүйлийн гэрэл зургийг харьцуулах хэмжээстэй авч хадгална.

5.11. Салбар комисс тооллогын ажлын өдөр тутмын тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд тухайн өдөр тооллогын ажилд оролцсон ажилтнууд гарын үсэг зурна.

5.12. Тооллогын дэвтрийг хөтөлж дуусмагц арын хавтасны дотор талд тухайн тооллогод хамрагдсан дурсгалт зүйлийн тоо, энэхүү журмын 5.8-д заасан нэмэлт, өөрчлөлтийн талаар тэмдэглэл үйлдэж, салбар комиссын гишүүд гарын үсэг зурна.

5.13. Тухайн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагын соёлын хяналтын улсын байцаагч тооллогын ажил холбогдох хууль, журмын дагуу явагдаж байгаад эсэхэд хяналт тавина.

5.14. Тооллогын явцад дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:



5.14.1. дурсгалт зүйлийг бүртгэлээс хасах, актлах, устгах;  
5.14.2. дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ жин, хадгалалтын байдлыг илэрхийлсэн бичвэрийг дур мэдэн засварлах;

5.14.3. дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх шийдвэр гаргах;

5.14.4. дурсгалт зүйлийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах, бусдад дамжуулах;

5.14.5. улсын комиссын гишүүн, соёлын хяналтын улсын байцаагчаас бусад этгээд аливаа хэлбэрээр хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

5.14.6. энэхүү журмын 6.3-т зааснаас бусад тохиолдолд тооллогын дэвтэр, цахим мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хувиан олшруулж авах, бусдад дамжуулах.

#### Зургаа. Тооллогын ажлын дүнг тайлагнах

6.1. Салбар комисс тооллогын ажил дууссанаас 14 хоногийн дотор дүнг нэгтгэн, дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлын талаар танилцуулга бэлтгэн аж ахуйн нэгж, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж санал, дүгнэлт гаргуулна.

6.2. Салбар комисс тооллогын ажил дууссанаас нэг сарын дотор комиссыг байгуулсан албан тушаалтанд тооллогын ажлын тайлан, энэхүү журмын 6.1-д заасан санал дүгнэлт болон тооллогын дэвтэр, “Тоолов (...он)” тэмдгийг хүлээлгэн өгнө.

6.3. Салбар комиссыг байгуулсан албан тушаалтан салбар комиссын тайланд мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулна. Дүгнэлтэд тооллогын ажил холбогдох хууль, журмын дагуу явагдсан эсэх, тооллогод хамрагдсан дурсгалт зүйлийн тоо болон дутсан, солигдсон, хулгайд алдагдсан дурсгалт зүйлийн талаарх мэдээллийг тусгана.

6.4. Салбар комиссыг байгуулсан Засгийн газрын гишүүн тооллогын дэвтрийг нэг хувь хувиан олшруулж тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хадгалуулна. Салбар комиссыг байгуулсан Засаг дарга тооллогын дэвтрийг хоёр хувь хувиан олшруулж тухайн аж ахуйн нэгж, байгууллага болон аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулна.





6.5. Салбар комиссыг байгуулсан албан тушаалтан тооллогын ажлын тайланг улсын байцаагчийн дүгнэлт, тооллогын дэвтэр, “Тоолов (...он)” тэмдэг болон тооллогын мөрөөр авах арга хэмжээний талаарх саналын хамт Улсын комисст хүргүүлнэ.

6.6. Улсын комисс тооллогын ажлын тайлан болон дэвтэр, “Тоолов (...он)” тэмдэг, бусад баримт бичгийн бүрдлийг нягтлан хүлээж авна.

6.7. Улсын комиссын дарга гурваас доошгүй гишүүнтэй баг томилж, “Тоолов (...он)” тэмдгийг устгалд оруулна.

6.8. Улсын комиссын дарга тооллогын ажлын дүн, авах арга хэмжээний саналыг нэгтгэн Засгийн газарт танилцуулна.

6.9. Улсын комиссын дарга тооллогын тайлан, дэвтэр, холбогдох бусад баримт бичгийг Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өгч, хадгалуулна.

#### Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 189

Улаанбаатар  
хот

### Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.3.3, Ногоон хөгжлийн бодлогын 3.6.4, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6 дахь зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрлэх, хэрэглэхийг 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хориглосугай.

2. Хог хаягдлын эдийн засгийн зохицуулалтыг сайжруулах, үүсгэгч нь хариуцаж, бохирдуулагч нь төлөх эко төлбөрийн эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад даалгасугай.



3. Энэ тогтоолын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Н.ЦЭРЭНБАТ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2018 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 209

Улаанбаатар  
хот

### **Хөтөлбөр батлах тухай**

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.7 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 56.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2018 оны 3 дугаар улиралд багтаан хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 255 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Н.ЦЭРЭНБАТ**

Засгийн газрын 2018 оны 209 дүгээр  
тогтоолын хавсралт

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

**1.1. Үндэсний хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээ шаардлага**

НҮБ-аас 2015 онд зохион байгуулсан Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтад 193 орны төр, засгийн тэргүүн нар оролцож, “Эх дэлхийгээ шинэчилье: Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрт ядуурлыг бууруулах, хүн амын эрүүл, аюулгүй байдлыг хангах, боловсролын чанар хүртээмжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг чиглэлээр 17 зорилго, 169 зорилтуудыг томъёолж, тэдгээрийг 2030 он хүртэл хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон. Эдгээр зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд тогтвортой хөгжлийн боловсрол чухал үүрэг гүйцэтгэхийг онцгойлон анхааруулж, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас баталсан “Тогтвортой хөгжлийн боловсролын дэлхий нийтийн үйл ажиллагааны хөтөлбөр (2015-2030)”-т нийцүүлэн үндэсний бодлого, хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг гишүүн орнуудад зөвлөмжилсөн.

Мөн НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жил” баримт бичигт “Тогтвортой хөгжлийн боловсрол нь хүн бүрт өнөөгийн болон хойч үеийнхээ төлөө соёлын ялгаатай байдлыг хүндэтгэн, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, нийгмийн шударга ёсыг хангаж, эдийн засгийн хувьд амьдрах чадвартай байж, мэдлэг, мэдээлэлтэй шийдвэр гаргах эрх мэдэл олгож буй явдал юм<sup>1</sup>” гэж тодорхойлсон болно.

<sup>1</sup>UNESCO, Shaping the future We want: Decade of Education for Sustainable Development (2005-2014), DESD Monitoring and Evaluation Final Report, Paris, 2014, pp.20



Монгол Улсын Засгийн газраас 1997 оны 255 дугаар тогтоолоор “Бүх нийтийн экологийн боловсрол” үндэсний хөтөлбөрийг дэлхий нийтийн XXI зууны тогтвортой хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн баталж, боловсролын тогтолцоог бүхэлд нь хамарсан шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж, албан болон албан бус боловсролын арга, хэлбэрээр бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэхэд багагүй хувь нэмрийг оруулсан бөгөөд уг хөтөлбөр нь 2005 онд хэрэгжиж дууссан.

Монголчууд эрт дээр үеэс байгалийн нөөц баялгийг зохистой ашиглаж, байгаль орчиндоо зохицон амьдарч ирсэн нүүдлийн соёл, уламжлалтай хэдий ч сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд хүн ам өсч, улс орны эдийн засаг хөгжихийн хэрээр хотжилт, байгаль орчны бохирдол, доройтол нэмэгдэж, байгалийн нөөцийг зохисгүй ашиглаж байгаагаас байгалийн онгон дагшин байдал, экосистемийн тэнцвэрт байдал алдагдах болсон. Тухайлбал, Улаанбаатар хотод агаар бохирдуулах зарим бодисын агууламж 2017-2018 оны хүйтний улиралд Монгол Улсын агаарын чанарын стандартаас 3 дахин давсан үзүүлэлттэй байна. Хууль бус ашигт малтмалын олборлолтын улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон 4000 гаруй га талбай байна. Монгол Улсын эдийн засаг байгалийн нөөцөөс ихээхэн хамааралтай хэдий ч нөөцийн үр ашиг маш доогуур буюу материалын ашиглалт (1 ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглаж байгаа материал) Ази, Номхон далайн бүсийн дунджаас 6 дахин, Япон улсынхтай харьцуулбал 56 дахин их байна. Энэ нь нөөц баялгийн үр ашиггүй, үрэлгэн хэрэглээ, техник технологийн хоцрогдол их байгаагийн нэг илрэл юм.

Иймд бүх түвшинд иргэн бүр өөрийн ахуй амьдрал, үйлдвэрлэл, хэрэглээний хэв маягаа эрс өөрчилж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлт, үр ашиг бүхий, хаягдал, бохирдол багатай үйлдвэрлэл хэрэглээний соёл, амьдралын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Энэхүү шаардлагын хүрээнд эх дэлхийгээ шүтэн хамгаалж ирсэн үндэсний өв уламжлал, байгаль орчинтойгоо зохицон амьдрах чадварыг шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл баримтлалаар баяжуулан бүх нийтэд түгээх, тогтвортой хөгжлийн боловсролын мэдлэг, мэдээллийг бүх шатны боловсрол, насан туршийн боловсролын тогтолцоогоор дамжуулан хүүхэд, залууст эзэмшүүлэх зорилт тавьж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 43 дугаар тогтоолоор дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тогтвортой хөгжлийг хангах тулгуур бодлого болох “Ногоон хөгжлийн бодлого”-ыг баталж, тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан эх оронч үзэл, байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маяг,

нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх зорилт дэвшүүлсэн.

Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт Засгийн газар “Иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах” гэж, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “албан болон албан бус боловсролын тогтолцооны хүрээнд иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил, байгаль орчныг хамгаалах арга, дадал олгох хөтөлбөрийг баталж биелэлтийг зохион байгуулна” гэж заасан, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.7-д “Тогтвортой хөгжлийн боловсрол” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, олон нийтэд эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгож, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.” гэсэн зорилтыг тусгасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

### 2.1. Хөтөлбөрийн зорилго

Бүх нийтэд байгаль орчноо хамгаалах, түүх, соёлын өвийг дээдлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг даван туулах, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлж, Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

### 2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1. Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсрол, мэргэжлийн болон дээд боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрийн агуулгыг байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл, аюулгүй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр баяжуулж, шаардагдах хүний нөөцийн болон материаллаг баазыг бэхжүүлнэ.

Зорилт 2. Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зарчмыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад таниулж, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд чиглэсэн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, үйл ажиллагааг уялдуулна.



Зорилт 3. Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг тасралтгүй эзэмшүүлж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ.

Зорилт 4. Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр бүх салбарын бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоо сайжруулж, салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

### 2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа:

Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ:

I үе шат (2018-2020 он)

II үе шат (2021-2022 он)

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. суралцагчдад тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг баяжуулж, хэрэгжүүлэх;

3.1.2. сургалтын байгууллагын барилга байгууламж, сургалтын хэрэглэгдэхүүнд байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлт, үр ашигтай байх шаардлага тавьж хэрэгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх;

3.1.3. сургалтын байгууллагуудын тогтвортой хөгжлийн санаачилгыг дэмжиж, олон талын оролцоо, манлайлал, хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх;

3.1.4. боловсролын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг тогтвортой хөгжлийн боловсролын зарчимд нийцүүлэх.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн талаар төр, хувийн хэвшил, иргэд, олон нийтэд нэгдсэн ойлголт бий болгоход чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

3.2.2. байгаль орчны менежментийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтан, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, ISO 14001 стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шилдэг туршлагыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх;

3.2.3. тогтвортой буюу ногоон худалдан авалтын зарчмыг нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, энэ чиглэлээр Засгийн газрын болон хувийн хэвшлийн (нийлүүлэгч) байгууллагуудын чадавхыг сайжруулах;

3.2.4. ус, эрчим хүч болон байгалийн бусад баялгийн хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаар олон нийтэд мэдлэг олгох, мэдээллийг түгээх;

3.2.5. шинжлэх ухаан, технологи, инновацийн судалгааг хөгжүүлж, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи бүхий төсөл, гарааны компанийг дэмжих, олон нийтэд нээлттэй мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх;

3.2.6. байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах тогтолцоог бий болгох.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. насан туршийн боловсролын хөтөлбөр, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтын агуулга, арга зүйг тусган хэрэгжүүлэх;

3.3.2. уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг бүс нутгийн иргэдэд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг даван туулах чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, мэдээллээр хангах;

3.3.3. тогтвортой хөгжлийн төлөөх үйл хэрэгт залуучуудын манлайлал, идэвхтэй оролцоо, санаачилгыг хөхиүлэн дэмжих;

3.3.4. хэвлэл мэдээллийн бүх төрлийн сувгаар нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх зорилгоор тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, ногоон ажлын байр, ногоон амьдралын хэв маяг, байгальд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээний талаарх мэдээллийг тогтмол түгээх.

3.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



3.4.1. бүх салбарын бодлого, хөтөлбөрт тусгасан тогтвортой хөгжлийн боловсролын үйл ажиллагааны уялдаа холбоо хангах;

3.4.2. тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх ажлыг үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах;

3.4.3. бүх нийтэд тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

#### Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

##### 4.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

4.1.1. бүх нийтээр (сургуулийн өмнөх болон бүх шатны сургуулийн насны хүүхдүүд, оюутнууд, ажилтнууд, гэр бүл, жирийн иргэд, ерх толгойлсон эмэгтэй) сурах, ажиллах, амьдрах хэв маягт байгаль орчноо хамгаалах, хэмнэлт, үр ашиг бүхий хэрэглээг төлөвшүүлэх, зөв дадал, эерэг хандлага бий болгох асуудлаар мэдлэг, мэдээллээр хангагдах, мэдээллийг саадгүй авах нөхцөл бүрдэнэ;

4.1.2. төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн байгууллагаас гарах аливаа шийдвэр нь тогтвортой хөгжлийн боловсролын асуудлаар харилцан уялдаатай хэрэгжих нөхцөл бүрдэнэ;

4.1.3. бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг эзэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэдийн оролцоо, дэмжлэг сайжирна;

4.1.4. бүс нутаг, хувь хүний онцлогт нийцсэн, соёлын олон янз байдлыг хүндэтгэх, байгаль орчноо хамгаалах, амьдралын зөв дадал, зуршлыг бий болгож, буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөлийг багасгах, үндэсний соёл уламжлалыг хүндэтгэх зэрэг асуудлаар нийгмийн ухамсар дээшилж, хэмнэлт, үр ашиг бүхий хэрэглээний соёл төлөвших үндэс суурь бүрдэнэ;

4.1.5. сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхэд байгаль орчноо хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэлттэй хэрэглэх, түүх соёлын өв, үндэсний зан заншлыг дээдлэх мэдлэг, боловсролтой болж, зөв дадал, эерэг хандлага бүхий иргэн болж төлөвших нөхцөл бүрдэнэ.



#### 4.2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

4.2.1. иргэд өөрийн амьдрах орчноо сайжруулж, тэгш, хүртээмжтэй боловсрол эзэмших, амьжиргаагаа дээшлүүлэх чадвартай болно;

4.2.2. иргэд болзошгүй эрсдэл, агаар, орчны бохирдлоос өөрийгөө хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний үр нөлөөг бууруулах чадвар, эрүүл амьдралын дадал хэвшил нэмэгдсэнээр эрүүл мэндийн улмаас учрах эдийн засгийн хохирол буурна;

4.2.3. иргэдийн тогтвортой хөгжлийн боловсрол дээшилснээр тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болж, үр ашиггүй зардал гаргахгүй болно;

4.2.4. хүрээлэн буй орчныг хамгаалах, энх тайван, шударга ёсыг хүндэтгэн, уламжлалт ёс заншлыг сахин биелүүлэх иргэдийн ухамсар дээшилснээр гэмт хэрэг, зөрчил багасч, төсвийн үр ашиггүй зардал буурна.

#### 4.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдалд хийсэн судалгааг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

Хөтөлбөрийн зорилт		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин			Хариуцах байгууллага
			2017	2020	2022	
1.	Зорилт-1. Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсрол, мэргэжлийн болон дээд боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрийн агуулгыг	Тогтвортой хөгжлийн боловсролын агуулга, арга зүй тусгагдах сургалтын хөтөлбөрийн тоо	143	148	155	БСШУСЯ
2.	байгальд эзлэх хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл,	Боловсролын салбарын хүний нөөцийн тогтвортой хөгжлийн боловсролын төрөлжсөн сургалтад хамрагдсан хувь	50	70	100	БСШУСЯ, БМДИ
3.		Олон улсын Эко сургууль хөтөлбөрт хамрагдах сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын байгууллагын тоо	255	350	450	БСШУСЯ, БОАЖЯ



4.	аюулгүй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр баяжуулж, шаардагдах хүний нөөцийн болон материаллаг баазыг бэхжүүлэх	Олон улсын “Ногоон” санаачилга үйл ажиллагааг нэвтрүүлэх дээд, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо	-	5	10	БСШУСЯ, БОАЖЯ
5.	хүний нөөцийн болон материаллаг баазыг бэхжүүлэх	“Эко”, “Ногоон” гэрчилгээ авах сургалтын байгууллагын тоо	45	60	80	БСШУСЯ, БОАЖЯ
6.	материаллаг баазыг бэхжүүлэх	Ногоон паспорттой сурагчдын эзлэх хувь	-	20	30	БСШУСЯ, БОАЖЯ
7.	Зорилт-2. Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зарчмыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад таниулж, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд чиглэсэн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, үйл ажиллагааг уялдуулах	Зохион байгуулагдах сургалт, арга хэмжээний тоо	6	6	8	БОАЖЯ, БСШУСЯ
8.	Зорилт-2. Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зарчмыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад таниулж, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд чиглэсэн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, үйл ажиллагааг уялдуулах	ISO 14000 багц стандартын батламж авах байгууллагын тоо	11	16	22	БОАЖЯ
9.	Зорилт-2. Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зарчмыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад таниулж, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд чиглэсэн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, үйл ажиллагааг уялдуулах	Эко тэмдэг авах бүтээгдэхүүн, ногоон гэрчилгээ авах байгууллагын тоо	2	10	20	БОАЖЯ
10.	Зорилт-2. Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зарчмыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад таниулж, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд чиглэсэн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, үйл ажиллагааг уялдуулах	Нийт ажлын байранд ногоон ажлын байрны эзлэх хувь	9.9	15	20	ҮСХ, ХНХЯ, ХХААХҮЯ
11.	Зорилт-3. Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг тасралтгүй эзэмшүүлж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх	Насан туршийн боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн боловсролын агуулга, арга зүй тусгагдах байдал, хувь	10	60	100	БСШУСЯ, НТБҮТ
12.	Зорилт-3. Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг тасралтгүй эзэмшүүлж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх	Тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр бэлтгэгдэх насан туршийн боловсролын төвийн сургагч багшийн эзлэх хувь	42	80	100	БСШУСЯ, НТБҮТ
13.	Зорилт-3. Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг тасралтгүй эзэмшүүлж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх	Тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр тогтмол мэдээлэл бэлтгэх хэвлэл мэдээллийн байгууллага, хувь	3	6	10	БОАЖЯ, БСШУСЯ, ХМБ
14.	Зорилт-3. Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг тасралтгүй эзэмшүүлж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэн тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэх	Тогтвортой хөгжлийн боловсролын төрөлжсөн сургалт, арга хэмжээнд хамрагдах сэтгүүлчдийн тоо	312	420	550	БОАЖЯ, БСШУСЯ, МХХ

15.	Зорилт-4. Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр бүх салбарын бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулж, салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Салбаруудын хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо	2	4	5	БСШУСЯ, БОАЖЯ
-----	---	---	---	---	---	------------------

#### Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж;

5.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, хөрөнгө;

5.1.4. бусад.

#### Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Үндэсний дэд зөвлөл ажиллана. Үндэсний дэд зөвлөл нь Тогтвортой хөгжлийн үндэсний хорооны дэргэд ажиллах бөгөөд дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангана.

6.3. Төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь салбарын, нутаг дэвсгэрийн болон



байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ.

6.4. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

#### Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

7.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жил бүр холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх бөгөөд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

7.3. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### ОЛОН УЛСЫН МАРГААНЫГ ЭНХИЙН ЗАМААР ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ 1907 ОНЫ КОНВЕНЦ

Германы Цог жавхланта эзэн хаан, Пруссийн хаан, Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Аргентин Улсын Ерөнхийлөгч, Австрийн Цог жавхланта эзэн хаан, Чехийн хаан зэрэг болон Унгарын угсаа залгамжлагч хаан, Бельгийн Цог жавхланта хаан, Бүгд Найрамдах Болив Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Бразилын Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч, Болгарын Хунтайж, Бүгд Найрамдах Чили Улсын Ерөнхийлөгч, Хятадын Эзэн хаан, Бүгд Найрамдах Колумб Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Куба Улсын Түр засаг дарга, Дани Улсын Цог жавхланта хаан, Бүгд Найрамдах Доминикан Улсын Ерөнхийлөгч, Бүгд

Найрамдах Эквадор Улсын Ерөнхийлөгч, Испани Улсын Цог жавхланта хаан, Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч, Их Британи, Ирланд болон Британы далайн чанад дахь эзэмшлийн Нэгдсэн Вант Улсын Цог жавхланта хаан, Энэтхэгийн эзэн хаан, Грекийн Цог жавхланта хаан, Бүгд Найрамдах Гватемал Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Гайти Улсын Ерөнхийлөгч, Италийн Цог жавхланта хаан, Япон Улсын Цог жавхланта эзэн хаан, Люксембургын Цог жавхланта гүн, Нассаугийн гүн, Мексикийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч, Монтенегро Улсын Цог жавхланта хунтайж, Бүгд Найрамдах Никарагуа Улсын Ерөнхийлөгч, Норвеги Улсын Цог жавхланта хаан, Бүгд Найрамдах Панама Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Парагвай Улсын Ерөнхийлөгч, Нидерланд Улсын Цог жавхланта Хатан хаан, Бүгд Найрамдах Перу Улсын Ерөнхийлөгч, Персийн Цогт жавхланта шейх, Румыны Цог жавхланта хаан, Бүх Оросын Цог жавхланта эзэн хаан, Бүгд Найрамдах Сальвадор Улсын Ерөнхийлөгч, Серби Улсын Цог жавхланта эзэн хаан, Сиамын Цог жавхланта хаан, Шведын Цог жавхланта хаан, Швейцарын Холбооны Улсын Зөвлөл, Оттоманы Цог жавхланта эзэн хаан, Дорно дахины Бүгд Найрамдах Уругвай Улсын Ерөнхийлөгч, Венесуэлын Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч:

Нийтийн энх тайвныг сахин хамгаалж ажиллах чин хүсэл эрмэлзэлд урамшин,

Олон улсын маргааныг эв зүйгээр шийдвэрлэхэд өөрсдийн бүх хүч чармайлтаар дэмжлэг үзүүлэхээр шийдэн,

Иргэншсэн үндэстний нийгмийн гишүүдийг нэгтгэх нийтлэг эрх ашгийг хүлээн зөвшөөрч,

Олон улсын шударга ёсыг эрхэмлэн бэхжүүлэх болон хуулийн ноёрхлыг түгээхийг эрмэлзэн,

Тусгаар улсуудын дундах бүх нийтэд нээлттэй Арбитрын шүүхийн байнгын институт нь энэхүү үр дүнд хүрэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт гүнээ итгэж,

Арбитрын ажиллагааны ерөнхий болон байнгын бүтэц зохион байгуулалтад оролцохын давуу талыг хүндэтгэн,

Ард түмний сайн сайхан байдал болон улсын аюулгүй байдалд тулгуурласан тэгш-шударга байдал болон эрхийн зарчмыг Олон улсын хэлэлцээрт тэмдэглэх нь чухал ач холбогдолтой болох тухай Олон улсын Энх тайвны Бага хурлын хүндэт санаачлагчийн саналыг хуваалцан,



Энэхүү зорилгоор Хэрэг бүртгэх хороо болон Арбитрын шүүхийн практик ажиллагааг сайжруулан баталгаажуулах болон хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхийг зөвшөөрсөн арбитрын ажиллагааг хялбаршуулахыг эрмэлзэн,

Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх Энх тайвны анхдугаар Бага хурлын ажлыг дуусгавар болгож, тодорхой асуудалд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэн,

Эрхэм дээд Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү зорилгоор шинэ конвенц байгуулахаар шийдвэрлэн, өөрсдийн дараахь бүрэн эрхт төлөөлөгчдийг томилов:

*/Энд Бүрэн эрхт төлөөлөгчдийн нэрс/*

Тэдгээрт зохих ёсоор олгогдсон бүрэн эрхийг журмын дагуу хадгалуулсны дараа дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

## **I ХЭСЭГ НИЙТИЙН ЭНХ ТАЙВНЫГ САХИН ХАМГААЛАХ**

### *1 дүгээр зүйл*

Улс хоорондын харилцаанд хүч хэрэглэх ойлголтоос аль болох зайлсхийж Хэлэлцэн тохиролцогч талууд олон улсын үзэл бодлын зөрүүг энхийн журмаар шийдвэрлэхэд хүчин чармайлт гарган ажиллахаар тохиролцов.

## **II ХЭСЭГ ЗУУЧЛАЛ БОЛОН ЭВЛЭРҮҮЛЭХ АЖИЛЛАГАА**

### *2 дугаар зүйл*

Ноцтой зөрчилдөөн, эсхүл маргаан гарсан тохиолдолд зэвсэгт хүрэхийн өмнө Хэлэлцэн тохиролцогч талууд нэг буюу түүнээс дээш найрсаг харилцаатай улсаас бололцооны хүрээнд зуучлуулах, эсхүл эвлэрүүлэх туслалцаа авахыг зөвшөөрнө.

### *3 дугаар зүйл*

Энэ аргаас гадна, Хэлэлцэн тохиролцогч талууд нэг буюу түүнээс дээш хөндлөнгийн улс өөрийн санаачлагаар, боломжит нөхцөлийн хүрээнд маргаж буй улсуудад зуучлалын болон эвлэрүүлэх санал тавихыг шаардлагатай бөгөөд тустай арга хэмжээ гэж үзнэ.



Хөндлөнгийн улс зуучлах, эсхүл эвлэрүүлэх саналыг дайны үед ч тавих эрхтэй.

Маргалдагч аль ч тал энэхүү эрхийн хэрэгжилтийг найрсаг бус үйлдэл гэж үзэхгүй.

*4 дүгээр зүйл*

Зуучлагчийн үндсэн үүрэгт улс хооронд үүсч болох өсөрхөг, таагүй харилцааг намжаах болон сөрөг нэхэмжлэлийг шийдвэрлэх ажиллагаа багтана.

*5 дугаар зүйл*

Зуучлагчийн чиг үүрэг зуучлагчийн санал болгосон эвлэрүүлэх аргыг зөвшөөрөх боломжгүй тухай зуучлагч өөрөө, эсхүл маргалдагч талуудын аль нэг нь зарласнаар дуусгавар болно.

*6 дугаар зүйл*

Маргалдагч талын хүсэлтээр, эсхүл хөндлөнгийн улсын санаачлагаар авсан зуучлах, эсхүл эвлэрүүлэх ажиллагаа нь гагцхүү зөвлөх шинжтэй байх бөгөөд заавал биелэгдэх шинжгүй.

*7 дугаар зүйл*

Хэрэв өөрөөр тохиролцоогүй бол эвлэрүүлэх ажиллагааг хүлээн зөвшөөрөх нь дайчилгаа явуулах, эсхүл дайнд бэлтгэх бусад арга хэмжээ авахад саад болох, түр зогсоох, эсхүл хойшлуулахад нөлөөлөхгүй.

Хэрэв энэхүү арга хэмжээг дайн бүхий байдал зарласнаас хойш авсан бол явагдаж буй цэргийн ажиллагааг өөрөөр тохиролцоогүй бол зогсоохгүй.

*8 дугаар зүйл*

Хэлэлцэн тохиролцогч талууд тусгай эвлэрүүлэн зуучлах ажиллагааг тухайн нөхцөлд тохируулан дараахь хэлбэрээр явуулахаар санал болгож болно. Үүнд:

Энх тайванд аюул учруулахуйц үзэл бодлын ноцтой зөрүү бий болсон тохиолдолд найрсаг харилцааг таслахаас сэргийлэх зорилгоор маргалдагч улс тус бүр нөгөө талын сонгосон улстай шууд яриа хэлэлцээнд орох үүрэг бүхий төлөөлөгчийг сонгоно.



Энэхүү бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацаа нь өөрөөр заагаагүй бол 30 хоногоос хэтрэхгүй байх бөгөөд энэ хугацаанд маргалдагч Талууд маргаантай асуудлаарх шууд харилцаагаа зогсоон, зуучлагч улс асуудлыг тусгайлан хариуцаж, маргааныг шийдвэрлэхэд бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллах үүрэгтэй.

Найрсаг харилцааг таслах нь тодорхой болсон тохиолдолд эдгээр улс нь энх тайвныг сэргээх аливаа боломжийг хайх хамтарсан үүрэгтэй.

### **III ХЭСЭГ ОЛОН УЛСЫН ХЭРЭГ БҮРТГЭХ ХОРОО**

#### *9 дүгээр зүйл*

Алдар хүнд, амин чухал ашиг сонирхлын аль нэгээс хамааралгүй бодит нөхцөл байдлын талаарх үзэл бодлын зөрүүнээс үүдэлтэй олон улсын шинжтэй маргааныг дипломат шугамаар шийдвэрлэж чадаагүй Талууд боломжит нөхцөлийн хүрээнд маргааныг шударга, чин үнэнчээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар баримтыг таниулж, маргааныг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгоор Олон улсын Хэрэг бүртгэх хороо байгуулахыг Хэлэлцэн тохиролцогч улсууд шаардлагатай бөгөөд тустай гэж үзнэ.

#### *10 дугаар зүйл*

Олон улсын Хэрэг бүртгэх хороог маргалдагч Талуудын хооронд байгуулсан тусгай хэлэлцээрээр байгуулна.

Хэрэг бүртгэх конвенцид шалгах баримтуудыг тодорхой заах бөгөөд Хороог байгуулах хэлбэр, цаг хугацаа болон Хорооны гишүүдийн бүрэн эрхийн хүрээг тодорхой заана.

Мөн шаардлагатай бол Хорооны байрлах газар, өөр газар нүүлгэж болох эсэх, Хорооны хэрэглэх хэл, үүнээс өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн хэл, түүнчлэн тал тус бүрийн баримт бүрдүүлж өгөх хугацаа болон ерөнхийдөө талуудын тохиролцсон бүхий л нөхцөлийг конвенцид тодорхой тусгана.

Хэрэв Талууд үнэлгээний шинжээч томилох шаардлагатай гэж үзвэл Хэрэг бүртгэх конвенцид түүнийг сонгох журам, бүрэн эрхийн хүрээг заана.



### *11 дүгээр зүйл*

Хэрэг бүртгэх конвенцид Хороо хаана байрлах тухай заагаагүй бол Гаг хотноо байрлана.

Хурал болох газрыг нэгэнт товлосон бол Хороо нь Талууд зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөрчлөхгүй.

Хэрэг бүртгэх конвенцид ямар хэл хэрэглэх талаар тодорхой заагаагүй бол энэ асуудлыг Хороо шийдвэрлэнэ.

### *12 дугаар зүйл*

Өөрөөр заагаагүй бол Хэрэг бүртгэх хороог энэхүү конвенцийн 45 болон 57 дугаар зүйлд зааснаар байгуулна.

### *13 дугаар зүйл*

Хорооны аль нэг гишүүн, эсхүл үнэлгээний аль нэг шинжээч нас барсан, огцорсон, эсхүл үүрэгт ажлаа цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон бол өмнөх томилгоог хийсэн журмын дагуу дараагийн хүнийг томилно.

### *14 дүгээр зүйл*

Талууд өөрсдийг нь төлөөлж Хороо болон Талуудын хооронд зуучлагчаар ажиллах үүрэг бүхий тусгай төлөөлөгчийг Хэрэг бүртгэх хороонд оролцуулахаар томилох эрхтэй.

Түүнчлэн Талууд Хорооны өмнө ашиг сонирхлыг нь илэрхийлэх, хэрэг танилцуулах зорилгоор өөрсдийн томилсон зөвлөх, эсхүл өмгөөлөгчийг ажиллуулах бүрэн эрхтэй.

### *15 дугаар зүйл*

Арбитрын байнгын шүүхийн Олон улсын товчоо нь Гаг хотноо байрлаж Хорооны бүртгэлийг хийх бөгөөд товчооны ажлын байр болон ажилтанг Хэрэг бүртгэх хорооны ажлын хэрэгцээнд зориулан Хэлэлцэн тохиролцогч Талд гаргаж өгнө.

### *16 дугаар зүйл*

Хороо Гаг хотоос өөр газар хуралдвал бүртгэлийн ажиллагаа явуулах Ерөнхий нарийн бичгийн даргыг тохоон томилно.



Ерөнхийлөгчийн удирдлагад ажиллах бүртгэгчийн чиг үүрэг нь Хорооны хурал явуулахад шаардлагатай зохион байгуулалтыг хангаж, хурлын тэмдэглэлийг бэлтгэн, хэрэг бүртгэл үргэлжлэх хугацаанд архивын асуудлыг хариуцан ажиллаж, дараа нь архивыг Гааг дахь Олон улсын товчоонд шилжүүлнэ.

#### *17 дугаар зүйл*

Талууд хэрэг бүртгэлийн ажиллагаанд хэрэглэх өөр журам батлаагүй бол Хэрэг бүртгэх хороо байгуулах болон үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талууд дараахь журмыг зөвлөмж болгоно.

#### *18 дугаар зүйл*

Хэрэг бүртгэх тусгай конвенц, эсхүл энэхүү конвенцид заагаагүй нарийвчилсан ажиллагааг Хороо шийдвэрлэх бөгөөд нотлох баримтын хүрээнд авах шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

#### *19 дүгээр зүйл*

Хэрэгт бүртгэгдсэн материалтай Талууд заавал танилцсан байна.

Тал тус бүр заасан хугацаанд Хороо болон нөгөө Талдаа хэргийн баримтын талаарх тайлбар мэдүүлэг болон бүх тохиолдолд үнэнийг нотлоход шаардлагатай гэж үзсэн баримт бичиг, дүрэм, журам түүнчлэн шүүх хуралд сонсохыг хүссэн нотлох баримтыг хэлэх гэрч, шинжээчдийн жагсаалтыг хүргүүлнэ.

#### *20 дугаар зүйл*

Хэрэг бүртгэх үйл ажиллагаанд ач холбогдолтой гэж үзсэн тохиолдолд Хороо Талуудын зөвшөөрлөөр өөр газар түр хугацаагаар нүүх, өөрийн нэг буюу түүнээс дээш гишүүнийг илгээх эрхтэй. Хэрэг бүртгэл явуулахаар санал болгож буй нутаг дэвсгэрт харьяалагдах улсаас зөвшөөрөл авсан байна.

#### *21 дүгээр зүйл*

Орон нутгийн мөрдөн байцаалт болон шалгалт бүрийг Талуудын төлөөлөгч болон зөвлөхийг байлцуулан, эсхүл тэдгээрт зохих ёсоор зарлан дуудах хүргүүлсний дараа хийнэ.

### *22 дугаар зүйл*

Хороо өөрийн шаардлагатай гэж үзсэн асуудлаар тайлбар, мэдээллийг аль ч талаас авах эрхтэй.

### *23 дугаар зүйл*

Талууд Хэрэг бүртгэх хороог маргаантай асуудлын талаар зөв ойлголт авах, асуудалтай бүрэн танилцахад шаардагдах арга хэрэгсэл, материаллаг баазаар бололцооны хэрээр хангах үүрэгтэй.

Талууд өөрийн нутаг дэвсгэрт байгаа Хорооны хуралд зарлан дуудагдсан гэрч, эсхүл шинжээчийг хуралд байлцуулах боломжтой арга хэмжээг дотоодын хуулийн дагуу авах үүрэгтэй.

Гэрч, эсхүл шинжээч Хорооны хуралд оролцох боломжгүй бол Талууд өөрийн улсын мэргэжлийн албаны хүмүүсийн өмнө нотлох баримтыг гаргуулах ажиллагааг зохион байгуулна.

### *24 дүгээр зүйл*

Хороо Хэлэлцэн тохиролцогч гуравдагч талын нутаг дэвсгэрт мэдэгдэл хүргүүлэхдээ тухайн улсын Засгийн газарт шууд хандана. Нотлох баримтыг газар дээр нь авах тохиолдолд үүнтэй адил журмыг хэрэглэнэ.

Энэхүү зорилгоор хүргүүлсэн хүсэлтийг хүлээн авсан улс дотоодын хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг авна. Тухайн улс нь өөрийн улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд хор хохиролтой гэж үзсэнээс бусад тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзахгүй.

Хороо нь байрлаж байгаа нутаг дэвсгэрийн улсаар дамжуулан үйл ажиллагаа явуулах байнгын тэгш эрхтэй байна.

### *25 дугаар зүйл*

Гэрч болон шинжээчийг Талуудын хүсэлтээр, эсхүл Хорооны саналаар бүх тохиолдолд тухайн этгээдийн оршин суугаа улсын Засгийн газраар дамжуулан зарлан дуудна.

Гэрчийг Хорооноос тогтоосон дарааллын дагуу төлөөлөгч болон зөвлөхийг байлцуулан тус тусад нь, дарааллан сонсоно.



### *26 дугаар зүйл*

Гэрчээс мэдүүлэг авах ажиллагааг Ерөнхийлөгч явуулна.

Гэхдээ Хорооны гишүүд үнэнийг олох зорилгоор гэрчийн мэдүүлэгтэй холбоотой аливаа асуудлаар тодруулга авах, нотлох баримт бүрдүүлэх, эсхүл мэдээлэл авах шаардлагатай гэж үзвэл гэрч тус бүрт асуулт тавьж болно. Талуудын төлөөлөгч, зөвлөх гэрчийг мэдүүлэг өгч байх үед тасалдуулж, шууд асуулт тавьж болохгүй боловч нэмэлт асуулт тавих шаардлагатай тохиолдолд хүсэлтээ Ерөнхийлөгчид гаргаж болно.

### *27 дугаар зүйл*

Гэрчийг нотлох баримт дэлгэх үед ямар нэгэн бичмэл тэмдэглэл уншихыг зөвшөөрөхгүй. Тухайн баримтын мөн чанараас хамааран тэмдэглэл болон бусад бичиг баримт ашиглах зайлшгүй шаардлагатай бол Ерөнхийлөгчөөс зөвшөөрөл авна.

### *28 дугаар зүйл*

Гэрчийн нотлох баримтын тэмдэглэлийг нэн даруй хөтөлж, гэрчид уншиж танилцуулна. Гэрч шаардлагатай гэж үзвэл тэмдэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай гэрчийн мэдүүлгийн төгсгөлд тэмдэглэнэ.

Мэдүүлгийг гэрчид бүрэн эхээр нь уншиж танилцуулаад гарын үсэг зуруулна.

### *29 дүгээр зүйл*

Төлөөлөгчид үнэнийг тогтооход ач холбогдолтой гэж үзсэн мэдэгдэл, шаардлага болон баримтын хураангуйг хэрэг бүртгэлийн явцад, эсхүл төгсгөлд нь Хороо болон нөгөө талдаа бичгээр танилцуулах эрхтэй байна.

### *30 дугаар зүйл*

Хороо шийдвэрээ хаалттай хэлэлцэх бөгөөд хянан шийдвэрлэх ажиллагаа нууц байна.

Бүх асуудлыг Хорооны гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүн санал өгөхөөс татгалзвал энэ тухай тэмдэглэлд дурдана.

### *31 дүгээр зүйл*

Хорооны хуралдаан хаалттай явагдах бөгөөд Талуудын зөвшөөрлийн үндсэн дээр Хорооноос шийдвэр гаргаснаас бусад



тохиолдолд хэрэг бүртгэлтэй холбоотой баримт бичиг, тэмдэглэлийг хэвлэн нийтлэхгүй.

*32 дугаар зүйл*

Талууд бүх тайлбар, нотлох баримтаа танилцуулж, бүх гэрчүүдийг сонссоны дараа Ерөнхийлөгч хэрэг бүртгэл дуусгавар болсныг зарлах бөгөөд Хороо зөвлөлдөн, дүгнэлтээ гаргахаар завсарлана.

*33 дугаар зүйл*

Дүгнэлтэд Хорооны бүх гишүүд гарын үсэг зурна. Аль нэг гишүүн гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай тэмдэглэх боловч энэ нь дүгнэлт хүчин төгөлдөр болоход нөлөөлөхгүй.

*34 дүгээр зүйл*

Хорооны дүгнэлтийг Талуудын төлөөлөгч, зөвлөхийг байлцуулан, эсхүл тэднийг зохих журмын дагуу зарлан дуудсаны үндсэн дээр олон нийтийн сонголоор уншиж танилцуулна. Дүгнэлтийн хуулбарыг Талуудад гардуулна.

*35 дугаар зүйл*

Хорооны дүгнэлт нь бодит баримтын мэдэгдлийн хүрээгээр хязгаарлагдах бөгөөд арбитрын шийдвэрийн шинжийг агуулахгүй. Мэдэгдлийг хүчин төгөлдөр болгох эрх нь Талуудад нээлттэй байна.

*36 дугаар зүйл*

Талууд өөрсдийн зардлыг хариуцах бөгөөд Хорооны үйл ажиллагаанд хамаарах зардлыг тэнцүү хувааж төлнө.

**IV ХЭСЭГ  
ОЛОН УЛСЫН АРБИТР**

**I Бүлэг  
Арбитрын тогтолцоо**

*37 дугаар зүйл*

Олон улсын арбитр нь улс хооронд үүссэн маргааныг Талуудын өөрсдийнх нь сонгосон шүүгчээр хууль дээдлэх зарчимд тулгуурлан шийдвэрлэх зорилготой.



Арбитрт хандаж буй нь арбитрын шийдвэрийг шударгаар даган биелүүлэхээ илэрхийлж буй хэрэг.

### *38 дугаар зүйл*

Арбитр нь олон улсын конвенцийг тайлбарлах, хэрэглэх болон бусад хууль зүйн шинжтэй асуудлыг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй арга бөгөөд дипломат шугамаар шийдвэрлэж чадаагүй маргааныг шийдвэрлэх хамгийн шударга арга хэрэгсэл гэдгийг Хэлэлцэн тохиролцогч талууд хүлээн зөвшөөрөв.

Иймд, дээр дурдсан асуудлаар маргаан гарсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талууд тухайн нөхцөлд нийцүүлэн арбитрт хандах нь зүйтэй.

### *39 дүгээр зүйл*

Энэхүү Арбитрын конвенц нь нэгэнт үүссэн, эсхүл хожим үүсч болох асуудлыг зохицуулах зорилготой.

Энэ нь аливаа маргааныг эсхүл зөвхөн тодорхой төрлийн маргааныг хянан шийдвэрлэж болно.

### *40 дүгээр зүйл*

Ерөнхий болон тусгай хэлэлцээрээр Хэлэлцэн тохиролцогч талыг арбитрт заавал хандахыг үүрэг болгосныг үл харгалзан дээр дурдсан Талууд арбитраар шийдвэрлүүлэх боломжтой гэж үзсэн бүх хэргийг заавал арбитраар шийдвэрлүүлэх зорилгоор ерөнхий болон тусгай гэрээг байгуулах эрхтэй.

## **II Бүлэг Арбитрын байнгын шүүх**

### *41 дүгээр зүйл*

Дипломат замаар шийдвэрлэх боломжгүй олон улсын санал зөрүүтэй асуудлаар арбитрт нэн даруй хандах ажиллагааг хялбаршуулах зорилгоор Энх тайвны анхдугаар бага хурлаар байгуулагдсан Арбитрын байнгын шүүхийг Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү конвенцид заасан хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу байнга ажиллуулах үүргийг хүлээнэ.

#### 42 дугаар зүйл

Талууд тусгай шүүх байгуулахаар тохиролцсоноос бусад тохиолдолд Байнгын шүүх арбитрын бүх хэргийг хянан шийдвэрлэх эрхтэй байна.

#### 43 дугаар зүйл

Байнгын шүүх нь Гааг хотод байрлана.

Олон улсын товчоо нь Шүүхийн бүртгэлийн ажлыг гүйцэтгэнэ. Товчоо нь хуралдаантай холбоотой асуудлаар харилцах суваг болох бөгөөд архив болон захиргааны үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй.

Хэлэлцэн тохиролцогч Талууд тэдний дунд ирүүлсэн арбитрын нөхцөлийн баталгаажсан хуулбар болон тэдгээрт хамаарах асуудлаар тусгай шүүхээс гаргасан шийдвэрийн баталгаажсан хуулбарыг Товчоонд аль болох богино хугацаанд мэдэгдэх үүрэг хүлээнэ.

Шүүхийн шийдвэрийг биелүүлсэн тухай баримт бичиг болон хууль, журмыг дээр дурдсанаар хүргүүлэх үүрэгтэй.

#### 44 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч улс тус бүр дээд тал нь 4 хүнийг сонгох бөгөөд тэдгээр нь олон улсын эрх зүйн асуудлаар сайн мэргэшсэн, өндөр ёс суртахуунтай байх бөгөөд арбитрчаар ажиллахыг зөвшөөрсөн байна.

Товчоо ийнхүү сонгогдсон хүмүүсийг Шүүхийн гишүүдийн жагсаалтад нэмж Хэлэлцэн тохиролцогчид мэдэгдэнэ.

Товчоо арбитрчдын жагсаалтад орсон аливаа өөрчлөлтийг Хэлэлцэн тохиролцогч улсад мэдэгдэнэ.

Хоёр буюу түүнээс дээш улс нэг буюу түүнээс дээш гишүүдийг хамт сонгохоор тохиролцож болно.

Нэг хүнийг хэд хэдэн улс сонгож болно. Шүүхийн гишүүнийг зургаан жилийн хугацаагаар томилно. Эдгээр томилгоог шинэчилж болно.

Шүүхийн гишүүн нас барсан, эсхүл чөлөөлөгдсөн бол түүнийг томилоход баримталсан журмын дагуу сул орон тоог нөхнө. Энэ тохиолдолд томилгоог зургаан жилийн хугацаагаар хийнэ.



#### 45 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч улсууд хоорондын саналын зөрүүтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Байнгын шүүхэд хандахыг хүсвэл маргааныг харьяалан шийдвэрлэх эрх бүхий Шүүхийг бүрдүүлэх арбитраждыг Шүүхийн гишүүдийн ерөнхий жагсаалтаас сонгоно.

Арбитрын шүүхийн бүрэлдэхүүний асуудлаар Талууд шууд тохиролцоонд хүрч чадаагүй бол дараахь журмыг мөрдөнө. Үүнд:

Тал тус бүр хоёр арбитражийг томилох бөгөөд тэдгээрийн зөвхөн нэг нь тухайн улсын иргэн, эсхүл тухайн улсын сонгосон Байнгын шүүхийн гишүүдийн нэг байж болно. Арбитражид хамтдаа Хөндлөнгийн шүүгчийг сонгоно.

Хэрэв санал тэнцүү хуваагдвал Талуудын харилцан зөвшөөрч, сонгосон гуравдагч улс Хөндлөнгийн шүүгчийг сонгоно.

Хэрэв энэ асуудлаар тохиролцож чадаагүй бол Тал тус бүр өөр өөр улсыг сонгох бөгөөд ийнхүү сонгогдсон улсууд Хөндлөнгийн шүүгчийг хамтран сонгоно.

Хэрэв хоёр сарын дотор дээрх хоёр улс тохиролцоонд хүрч чадаагүй бол Байнгын шүүхийн гишүүдийн нэрсийн жагсаалтаас улс тус бүр Талуудаас сонгогдоогүй бөгөөд эдгээр улсын аль алины нь иргэн бус хоёр нэр дэвшигчийг тус тус санал болгоно. Хөндлөнгийн шүүгчийг эдгээр нэр дэвшигчдээс сугалаагаар сонгоно.

#### 46 дугаар зүйл

Арбитрын бүрэлдэхүүнийг ийнхүү байгуулсны дараа Талууд шүүхэд хандахаар шийдвэрлэсэн тухайгаа, “Хэлцэл” болон арбитраждын нэрсийн хамт Товчоонд мэдэгдэнэ.

Товчоо нь арбитраж тус бүрт “Хэлцэл” болон арбитрын бүрэлдэхүүнд орсон бусад гишүүдийн нэрсийг нэн даруй хүргүүлнэ.

Арбитрын бүрэлдэхүүн Талуудын товлосон өдөр хуралдана. Товчоо хуралд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авна.

Арбитрын бүрэлдэхүүний гишүүн эх орноосоо гадна үүрэг гүйцэтгэж байхдаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ.



#### 47 дугаар зүйл

Товчоо нь Арбитрын тусгай зөвлөлийн үйл ажиллагаанд зориулан өөрийн ажлын байр болон ажилтнуудыг Хэлэлцэн тохиролцогч улсын ажлын хэрэгцээнд гарган өгч болно.

Талууд энэхүү арбитрын бүрэлдэхүүнд хандахаар тохиролцсон бол журамд заасан нөхцөлийн дагуу Байнгын шүүхийн харьяаллыг Хэлэлцэн тохиролцогч бус улс хооронд, эсхүл Хэлэлцэн тохиролцогч болон Хэлэлцэн тохиролцогч бус улс хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөтгөж болно.

#### 48 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч хоёр буюу түүнээс дээш улс хооронд ноцтой маргаан гарах нөхцөл бий болсон үед Байнгын шүүх тэдэнд нээлттэй байгааг сануулах нь Хэлэлцэн тохиролцогч улсын үүрэг гэж ойлгоно.

Иймд, маргааныг энхийн замаар шийдвэрлэх зорилгоор энэхүү конвенцийн заалтыг сануулан маргалдагч Талуудыг Байнгын шүүхэд хандахыг зөвлөж буй нь гагцхүү нөхөрсөг үйл хэрэгт тооцогдоно.

Хоёр улсын хооронд маргаан гарсан тохиолдолд тэдний нэг нь маргаанаа арбитраар шийдвэрлүүлэх хүсэлт гаргахад бэлэн байгаа тухайгаа илэрхийлсэн мэдэгдлийг Олон улсын товчоонд ноот бичгээр хүргүүлж болно.

Товчоо энэ мэдэгдлийг нөгөө улсад нэн даруй мэдэгдэнэ.

#### 49 дүгээр зүйл

Гааг хотноо итгэмжлэгдсэн Хэлэлцэн тохиролцогч улсын дипломат төлөөлөгч болон Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх Нидерландын Гадаад хэргийн сайдаас бүрдсэн Захиргааны байнгын зөвлөл нь Олон улсын товчоог удирдаж, хяналт тавих үүрэгтэй.

Зөвлөл өөрийн үйл ажиллагааны дүрэм болон бусад бүх шаардлагатай журмыг батална.

Зөвлөл Шүүхийн үйл ажиллагааны талаар үүсч болох захиргааны шинжтэй бүхий л асуудлыг шийдвэрлэнэ.

Зөвлөл Товчооны ажилтан, албан хаагчдыг томилох, түдгэлзүүлэх болон чөлөөлөх асуудлыг бүхэлд нь хариуцана.



Мөн төлбөр, цалинг тогтоож, ерөнхий зарцуулалтад хяналт тавина.

Зохих ёсоор зарлагдсан хуралд есөн гишүүн хүрэлцэн ирснээр Зөвлөлийн хэлэлцүүлгийг хүчинтэйд тооцно. Шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

Зөвлөл нь өөрийн баталсан журмаа Хэлэлцэн тохиролцогч талуудад даруй мэдэгдэнэ. Мөн шүүхийн ачаалал, зөвлөлийн захиргааны үйл ажиллагаа болон зарцуулалтын жилийн тайланг Талуудад гаргаж өгнө. Тайланд улсуудын зүгээс 43 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу Товчоонд ирүүлсэн баримт бичгийн чухал хэсгийг товчлон оруулна.

#### *50 дугаар зүйл*

Товчооны зардлыг Хэлэлцэн тохиролцогч улс Дэлхийн шуудан холбооны Олон улсын товчоонд зориулан тогтоосон хэмжээгээр хариуцна.

Нэгдэн орж буй улсад ногдох зардлыг тухайн улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцно.

### **III бүлэг Арбитрын ажиллагаа**

#### *51 дүгээр зүйл*

Талууд өөр журам хэрэглэхээр тохиролцоогүй бол арбитрын хөгжлийг дэмжих зорилгоор арбитрын хянан шийдвэрлэх ажиллагаанд дараахь журмыг баримтлахаар хэлэлцэн тохиролцов.

#### *52 дугаар зүйл*

Арбитрт хандаж буй улс маргааны зүйлийг тодорхой заасан, арбитрчдыг томилох хугацаа, 63 дугаар зүйлд заасан асуудлаар харилцах хэлбэр, дараалал, хугацаа, Талуудын урьдчилж төлбөл зохих арбитрын зардлын төлбөрийн хэмжээ зэргийг тусгасан «Хэлцэл»-д гарын үсэг зурна.

Шаардлагатай бол “Хэлцэл»-д арбитрчийг томилох хэлбэр, арбитрын бүрэлдэхүүнд олгох тусгай бүрэн эрх, хурал болох газар, хэрэглэх хэл, үүнээс өмнө хэрэглэхээр зөвшөөрсөн хэл болон ерөнхийдөө Талуудын тохиролцсон бүх нөхцөлийг тодорхой тусгана.

### 53 дугаар зүйл

Талууд Байнгын шүүхэд “Хэлцэл”-тэй холбоотой асуудлаар хандахаар тохиролцсон бол Байнгын шүүх нь “Хэлцэл”-ийг шийдвэрлэх бүрэн эрхтэй байна.

Дипломат журмаар тохиролцоонд хүрэх бүх оролдлого амжилтгүй болсон үед зөвхөн аль нэг тал хүсэлт гаргаснаар дараахь тохиолдолд шүүх бүрэн эрхийнхээ хүрээнд уг асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш байгуулсан, эсхүл шинэчилсэн Арбитрын ерөнхий хэлэлцээрт хамаарах маргаан бөгөөд бүх маргааны хувьд “Хэлцэл” хийх нөхцөлийг бүрдүүлсэн байх, «Хэлцэл»-ийн асуудлаарх маргааныг шүүхээр хянан шийдвэрлүүлэхгүй гэж тодорхой болон тодорхой бус байдлаар тусгаагүй бол шүүхээр шийдвэрлэнэ. Харин Арбитрын хэлэлцээрээр Арбитрын шүүхэд энэхүү урьдчилсан асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрх олгосноос бусад тохиолдолд нөгөө тал уг маргааныг арбитраар заавал хянуулах маргааны төрөлд хамаарахгүй гэж мэдэгдсэн бол шүүхэд хандах боломжгүй.

2. Нэг улс нөгөө улсаас нэхэмжилсэн өөрийн иргэний төлбөл зохих гэрээний төлбөртэй холбоотой маргааныг арбитраар шийдвэрлүүлэх хүсэлтийг хүлээн авсан бол шүүхээр шийдвэрлэнэ. Харин “Хэлцэл”-ийг өөр бусад хэлбэрээр шийдвэрлэх нөхцөлөөр хүлээн авсан бол энэхүү зохицуулалтыг хэрэглэхгүй.

### 54 дүгээр зүйл

Өмнөх зүйлд заасан тохиолдолд “Хэлцэл”-ийг 45 дугаар зүйлийн 3-6 дахь хэсэгт заасан хэлбэрээр сонгогдсон таван гишүүний бүрэлдэхүүнтэй Хороо шийдвэрлэнэ.

Тав дахь гишүүн нь албан үүргийн *lex officio* дагуу Хорооны ерөнхийлөгч байна.

### 55 дугаар зүйл

Арбитрчийн үүргийг энэхүү конвенцийн дагуу байгуулагдсан Арбитрын байнгын шүүхийн гишүүдээс Талуудын сонгосон, эсхүл Талуудын өөрийн үзэмжээр сонгосон нэг, эсхүл хэд хэдэн арбитрчид даалгаж болно.

Талууд арбитрын бүрэлдэхүүнийг шууд тохиролцон бүрдүүлж чадаагүй бол 45 дугаар зүйлийн 3-6 дахь хэсэгт заасан журмыг баримтална.



*56 дугаар зүйл*

Төрийн тэргүүн, эсхүл эзэн хааныг Арбитрчаар сонгосон бол тэрээр арбитрын хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтооно.

*57 дугаар зүйл*

Хөндлөнгийн шүүгч нь албан үүргийн дагуу *lex officio*/ Арбитрын бүрэлдэхүүний Ерөнхийлөгч байна.

Арбитрын бүрэлдэхүүнд Хөндлөнгийн шүүгч ороогүй бол Ерөнхийлөгчөө өөрсдөө томилно.

*58 дугаар зүйл*

“Хэлцэл”-ийг 54 дүгээр зүйлд заасны дагуу Хороо шийдвэрлэх тохиолдолд мөн гэрээнд өөрөөр заагаагүй бол Хороо өөрөө Арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлнэ.

*59 дүгээр зүйл*

Арбитрчдын аль нэг нь нас барсан, тэтгэвэрт гарсан, эсхүл аливаа шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд сул орон тоог түүнийг томилоход баримталсан журмын дагуу нөхнө.

*60 дугаар зүйл*

Талууд өөр газар сонгоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн Гааг хотноо байрлана.

Арбитрын бүрэлдэхүүн гуравдагч улсын нутаг дэвсгэрт зөвхөн түүний зөвшөөрөлтэйгээр байрлаж болно.

Хурал болох газрыг нэгэнт товлосон бол Талуудын зөвшөөрөлгүйгээр Арбитрын бүрэлдэхүүн өөрчилж болохгүй.

*61 дүгээр зүйл*

“Хэлцэл”-д хэрэглэх хэлийг тодорхой заагаагүй бол Арбитрын бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ.

*62 дугаар зүйл*

Талууд Арбитрын бүрэлдэхүүн болон тэдний хооронд зуучлагчаар ажиллаж Арбитрын хуралд оролцох тусгай төлөөлөгчийг томилох эрхтэй.

Энэхүү зорилгын дагуу Арбитрын бүрэлдэхүүний өмнө өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зөвлөх буюу өмгөөлөгчийг томилон ажиллуулах бүрэн эрхтэй байна.

Байнгын шүүхийн гишүүд нь өөрийг нь шүүхийн гишүүнээр томилсон улсаас бусад улсын нэрийн өмнөөс төлөөлөгч, зөвлөх, өмгөөлөгчөөр ажиллаж болохгүй.

### *63 дугаар зүйл*

Нийтлэг журмын дагуу арбитрын ажиллагаа нь бичгээр нотлох баримт хүлээн авах болон аман хэлэлцүүлэг хийх гэсэн хоёр тусдаа үе шатаас бүрдэнэ.

Бичгээр нотлох баримт хүлээн авах үе шат нь холбогдох төлөөлөгчөөр дамжуулан Арбитрын бүрэлдэхүүний гишүүд болон хэргийн эсрэг тал хооронд харилцсан бичиг, хэргийн сөрөг тайлбар болон шаардлагатай тохиолдолд хариу тайлбараас бүрдэх бөгөөд Талууд хэрэгт цуглуулсан бүх бичиг баримтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг “Хэлцэл”-д заасан хугацаа, дарааллын дагуу Олон улсын товчооны зуучлагчаар дамжуулан, эсхүл шууд хүргүүлнэ.

“Хэлцэл”-д заасан хугацааг Талууд харилцан тохиролцсоноор, эсхүл шударга шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзвэл Арбитрын бүрэлдэхүүн сунгаж болно.

Хэлэлцүүлэг нь Талуудын бүрдүүлсэн нотлох баримтыг Арбитрын бүрэлдэхүүний өмнө амаар танилцуулах үйл ажиллагаанаас бүрдэнэ.

### *64 дүгээр зүйл*

Талууд өөрийн бүрдүүлсэн баримт бичиг тус бүрийн баталгаажуулсан хуулбарыг нөгөө талдаа заавал хүргүүлнэ.

### *65 дугаар зүйл*

Онцгой нөхцөл байдал үүсэхээс бусад тохиолдолд бичгээр нотлох баримт цуглуулах ажиллагаа дуусгавар болохоос өмнө Арбитрын бүрэлдэхүүн хуралдахгүй.

### *66 дугаар зүйл*

Хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн удирдлага дор явуулна. Арбитрын бүрэлдэхүүн Талуудын зөвшөөрлийг үндэслэн хэлэлцүүлгийг нээлттэй явуулах шийдвэр гаргасан тохиолдолд л хэлэлцүүлгийг нээлттэй явуулна.



Хэлэлцүүлгийн тэмдэглэлийг Ерөнхийлөгчийн томилсон Нарийн бичгийн дарга нар хөтөлнө. Хурлын тэмдэглэлд Ерөнхийлөгч болон Нарийн бичгийн даргын нарын нэг нь гарын үсэг зурах бөгөөд энэ нь дангаараа жинхэнэ эх баримт болно.

*67 дугаар зүйл*

Арбитрын бүрэлдэхүүн бичгээр нотлох баримт хүлээн авах хугацаа дууссаны дараа нөгөө талынхаа зөвшөөрөлгүйгээр аль нэг талаас хүргүүлж буй бүх шинэ баримт бичгийг хэлэлцүүлэхээс татгалзах эрхтэй.

*68 дугаар зүйл*

Арбитрын бүрэлдэхүүн Талуудын төлөөлөгч буюу зөвлөхийн зүгээс онцолсон шинэ баримт бичиг, мэдээллийг хянан үзэж болно.

Энэ тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн тухайн баримт бичгийг боловсруулахыг шаардах эрхтэй боловч энэ тухай эсрэг Талд мэдэгдэх үүрэгтэй.

*69 дүгээр зүйл*

Түүнчлэн Арбитрын бүрэлдэхүүн Талуудын төлөөлөгчөөс бүх баримт бичгийг боловсруулахыг болон шаардлагатай бүх тайлбарыг гаргаж өгөхийг шаардаж болно. Татгалзсан тохиолдолд Арбитрын бүрэлдэхүүн энэ тухай тэмдэглэнэ.

*70 дугаар зүйл*

Талуудын төлөөлөгч, зөвлөх өөрсдийн хэргийг хамгаалахад шаардлагатай гэж үзсэн бүхий л нотлох баримтыг Арбитрын бүрэлдэхүүнд амаар танилцуулах бүрэн эрхтэй.

*71 дүгээр зүйл*

Тэд эсэргүүцэх болон асуудал дэвшүүлэх эрхтэй. Арбитрын бүрэлдэхүүнээс эдгээр асуудлаар гаргасан шийдвэр эцсийнх байх бөгөөд дараа дараагийн хэлэлцүүлгийн сэдэв болохгүй.

*72 дугаар зүйл*

Арбитрын бүрэлдэхүүний гишүүд Талуудын төлөөлөгч болон зөвлөхөд асуулт тавих болон эргэлзээтэй асуудалд тайлбар авах эрхтэй.

Хэлэлцүүлгийн явцад Арбитрын бүрэлдэхүүний гишүүдээс тавьсан асуулт, хэлсэн үгийг Арбитрын бүрэлдэхүүний, эсхүл түүний гишүүдийн үзэл бодол гэж үзэхгүй.

*73 дугаар зүйл*

Арбитрын бүрэлдэхүүн “Хэлцэл” болон холбогдох бусад гэрээг тайлбарлах болон эрх зүйн зарчмыг хэрэглэх чадамжтай болохоо зарлах бүрэн эрхтэй.

*74 дүгээр зүйл*

Арбитрын бүрэлдэхүүн Талуудын баримт бичгээ эцэслэн гаргаж өгөх хугацаа, хэлбэр, дарааллыг тогтоох, нотлох баримтыг хүлээн авч шийдвэрлэхэд шаардлагатай зохицуулалтыг хийх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг гаргах бүрэн эрхтэй.

*75 дугаар зүйл*

Талууд бүрэн боломжтой гэж үзвэл хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой бүх мэдээллийг Арбитрын бүрэлдэхүүнд гаргаж өгөх үүрэгтэй.

*76 дугаар зүйл*

Арбитрын бүрэлдэхүүн Хэлэлцэн тохиролцогч гуравдагч талын нутаг дэвсгэрт мэдэгдэл хүргүүлэхдээ тухайн улсын Засгийн газарт шууд хандана. Нотлох баримтыг газар дээр нь авах тохиолдолд үүнтэй адил журмыг хэрэглэнэ. Энэхүү зорилгоор хүргүүлсэн хүсэлтийг хүлээн авсан улс дотоодын хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ авна. Тухайн улс нь өөрийн улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд хор хохиролтой гэж үзсэнээс бусад тохиолдолд уг хүсэлтийг хүлээн авахаас татгалзахгүй.

Шүүх өөрийн байрлаж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах улсаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулах байнгын тэгш эрхтэй байна.

*77 дугаар зүйл*

Талуудын төлөөлөгч болон зөвлөх өөрийн хэрэгт хамаарах бүх тайлбар, нотлох баримтыг мэдүүлснээр Ерөнхийлөгч хэлэлцүүлэг хаасныг мэдэгдэнэ.

*78 дугаар зүйл*

Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрээ хаалттай хэлэлцэх бөгөөд хянан шийдвэрлэх ажиллагаа нууц байна.

Арбитрын гишүүдийн олонхийн шийдвэрээр бүх асуудлыг шийдвэрлэнэ.



### *79 дүгээр зүйл*

Арбитрын шийдвэрт үндэслэлийг заасан байна. Шийдвэрт Арбитрчдын нэрийг дурдаж Ерөнхийлөгч болон Бүртгэгч, эсхүл Бүртгэгчийн үүрэг гүйцэтгэсэн Нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

### *80 дугаар зүйл*

Арбитрын шийдвэрийг Талуудын төлөөлөгч, зөвлөхийг байлцуулан, эсхүл тэднийг зохих журмын дагуу зарлан дуудсаны үндсэн дээр олон нийтийн сонсголоор уншиж танилцуулна.

### *81 дүгээр зүйл*

Зохих журмын дагуу Талуудын төлөөлөгчдөд мэдэгдэж, сонордуулсан арбитрын шийдвэр нь маргааныг давж заалдах эрхгүйгээр эцэслэн шийдвэрлэнэ.

### *82 дугаар зүйл*

Арбитрын шийдвэрийг тайлбарлах болон гүйцэтгэхтэй холбоотойгоор Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг өөр хэлэлцээр байхгүй бол түүнийг сонордуулсан арбитрын бүрэлдэхүүнд хүргүүлнэ.

### *83 дугаар зүйл*

Талууд Арбитрын шийдвэрт өөрчлөлт оруулахыг шаардах эрхээ “Хэлцэл”-д тусгаж болно.

Энэ тохиолдолд болон өөр Хэлэлцээр байхгүй бол уг шаардлагыг Арбитрын шийдвэрийг сонордуулсан Арбитрын бүрэлдэхүүнд хаяглаж хүргүүлнэ. Үүнийг зөвхөн арбитрын шийдвэрт шийдвэрлэх нөлөө үзүүлэх магадлалтай бөгөөд хэлэлцүүлэг дуусгавар болох үед арбитрын бүрэлдэхүүн болон шийдвэрийг өөрчлөх шаардлага гаргаж буй талд өмнө нь мэдэгдээгүй нөхцөл байдал шинээр илэрсэн гэх үндэслэлээр гаргана.

Шийдвэрт өөрчлөлт оруулах асуудлыг хянан шалгах үйл ажиллагааг зөвхөн Арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийн дагуу шинээр илэрсэн нөхцөл байдлыг тодорхой тэмдэглэж, өмнөх хэсэгт заасан шинж чанарыг агуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, энэхүү үндэслэлээр шаардлагыг хүлээн авахаа мэдэгдэх журмаар явуулна.

Шийдвэрт өөрчлөлт оруулах шаардлагыг хэрэгжүүлэх хугацааг “Хэлцэл”-д заавал заана.



#### *84 дүгээр зүйл*

Арбитрын шийдвэр нь маргалдагч бус талын хувьд заавал биелэгдэх шинжгүй.

Маргалдагч бус улсын нэгдэн орсон конвенцийн тайлбарыг гарын үсэг зурсан бүх улсад цаг хугацаанд нь мэдэгдэнэ. Эдгээр улс уг асуудалд хөндлөнгөөс оролцох эрхтэй. Хэрэв нэг буюу түүнээс дээш улс энэ эрхээ эдлэвэл арбитрын шийдвэрт хамаарах тайлбарыг заавал биелүүлэх үүрэгтэй.

#### *85 дугаар зүйл*

Тал тус бүр өөрийн зардал болон Арбитрын бүрэлдэхүүний зардлыг тэнцүү хувааж төлнө.

### **IV Бүлэг Хялбаршуулсан журмаар явуулах арбитрын ажиллагаа**

#### *86 дугаар зүйл*

Маргааныг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх арбитрын системийн үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор Хэлэлцэн тохиролцогч талууд дараах журмыг өөр зохицуулалт байхгүй тохиолдолд мөрдлөг болгохоор батлав. Ингэхдээ, III Бүлгийн заалтыг хэрэглэх тухай тайлбар хийж болно.

#### *87 дугаар зүйл*

Маргалдагч тал тус бүр нэг Арбитрчийг томилно. Ийнхүү сонгогдсон хоёр Арбитрч Хөндлөнгийн шүүгчийг сонгоно. Хэрэв энэ асуудлаар тохиролцож чадаагүй бол улс тус бүр Байнгын шүүхийн гишүүдийн нэрсийн ерөнхий жагсаалтаас өөрийн томилоогүй бөгөөд эдгээр улсын аль алины нь иргэн бус хоёр нэр дэвшигчийг тус тус санал болгох бөгөөд санал болгосон нэр дэвшигчдээс Хөндлөнгийн шүүгчийг сугалаагаар сонгоно.

Хөндлөнгийн шүүгч Арбитрын бүрэлдэхүүнийг тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүн шийдвэрээ олонхийн саналаар гаргана.

#### *88 дугаар зүйл*

Өмнө нь өөрөөр хэлэлцэн тохиролцоогүй бол Арбитрын бүрэлдэхүүн бүрдмэгц холбогдох хэргийг арбитрт ирүүлэх хугацааг тогтооно.



### *89 дүгээр зүйл*

Талууд Арбитрын бүрэлдэхүүний өмнө өөрсдийг нь төлөөлж, Арбитрын бүрэлдэхүүн болон Засгийн газар хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэх төлөөлөгчийг томилно.

### *90 дүгээр зүйл*

Хянан шийдвэрлэх ажиллагааг гагцхүү бичгээр явуулна. Гэхдээ тал тус бүр гэрч, шинжээчийг дуудах хүсэлтийг тавих эрхтэй. Арбитрын бүрэлдэхүүн талуудын төлөөлөгч болон шүүх хуралд оролцох нь ач холбогдолтой гэж үзсэн шинжээч, гэрчүүдээс амаар тайлбар өгөхийг шаардах эрхтэй.

## **V ХЭСЭГ ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ**

### *91 дүгээр зүйл*

Зохих ёсоор соёрхон батлагдсан энэхүү конвенц нь Хэлэлцэн тохиролцогч улс хооронд Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1899 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн конвенцийг орлоно.

### *92 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг аль болох богино хугацаанд соёрхон батална.

Соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Гаг хотноо хадгалуулна.

Соёрхон баталсан тухай баримт бичгийн эхний хэсгийг хадгалахдаа оролцогч улсын төлөөлөл болон Нидерландын Вант Улсын Гадаад хэргийн сайдын гарын үсэг бүхий тэмдэглэлийг бичгээр үйлднэ.

Үүний дараа соёрхон баталсан тухай баримт бичгийг хадгалуулахдаа Нидерландын Вант Улсын Засгийн газарт бичгээр мэдэгдэн соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг хүргүүлнэ.

Эхний хэсгийн эх хадгалах үйл ажиллагааны тэмдэглэл, өмнөх хэсэгт заасан мэдэгдэл болон соёрхон баталсан тухай батламж жуух бичгийн баталгаат хуулбарыг Нидерландын Вант Улсын Засгийн газраас Энх тайвны хоёрдугаар бага хуралд уригдсан улс болон конвенцид нэгдэн орсон улсад дипломат шугамаар нэн даруй хүргүүлнэ. Өмнөх хэсэгт заасны дагуу уг Засгийн газар мэдэгдлийг хүлээн авсан өдрийг улсуудад мэдэгдэнэ.

### *93 дугаар зүйл*

Энх тайвны хоёрдугаар бага хуралд уригдсан бөгөөд гарын үсэг зураагүй улс энэхүү конвенцид нэгдэн орж болно.

Нэгдэн орох улс хүсэлтээ Нидерландын Вант Улсын Засгийн газарт бичгээр тавьж, нэгдэн орсон тухай баримт бичгийг хүргүүлэн Нидерландын Вант Улсын Засгийн газрын архивт хадгалуулна.

Нидерландын Вант Улсын Засгийн газар нь Энх тайвны хоёрдугаар бага хуралд уригдсан бусад бүх улсад уг мэдэгдлийг хүлээн авсан огноог дурдсан мэдэгдэл болон нэгдэн орох тухай баримт бичгийн баталгаат хуулбарыг нэн даруй хүргүүлнэ.

### *94 дүгээр зүйл*

Энх тайвны хоёрдугаар Бага хуралд уригдаагүй улс энэхүү конвенцид нэгдэн орж болох тухай нөхцөл нь Хэлэлцэн тохиролцогч улс хоорондын дараагийн хэлэлцээрийн зүйл болно.

### *95 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь батламж жуух бичгийн эхийн эхний хэсгийн хадгалалтад хамааралгүй улсын хувьд энэхүү баримт бичиг хадгалуулсан тухай тэмдэглэл үйлдсэн өдрөөс хойш 60 өдрийн дараа, түүний дараа соёрхон батлах, эсхүл нэгдэн орох улсын хувьд соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон тухай мэдэгдлийг Нидерландын Вант Улсын Засгийн газар хүлээн авснаас хойш 60 өдрийн дараа хүчин төгөлдөр болно.

### *96 дугаар зүйл*

Аль нэг Хэлэлцэн тохиролцогч тал энэхүү конвенцийг цуцлах тухай хүсэлтээ Нидерландын Вант Улсын Засгийн газарт бичгээр мэдэгдэнэ. Уг мэдэгдлийн баталгаажсан хуулбарыг хүлээн авсан өдрийн хамт бусад улсад зохих журмын дагуу нэн даруй мэдэгдэнэ.

Цуцлалт нь зөвхөн мэдэгдэл хийсэн улсын хувьд Нидерландын Вант Улсын Засгийн газар мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

### *97 дугаар зүйл*

Нидерландын Гадаад хэргийн сайдын хөтөлөх бүртгэлд 92 дугаар зүйлийн 3 болон 4 дүгээр хэсэгт заасан батламж жуух бичгийг хадгалсан өдөр, конвенцид нэгдэн орсон тухай мэдэгдэл (93 дугаар зүйлийн 2 дахь



хэсэг), эсхүл цуцлах тухай мэдэгдэл (96 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) -ийг хүлээн авсан огноог бүртгэнэ.

Хэлэлцэн тохиролцогч тал бүр энэхүү бүртгэлд нэвтрэх болон түүнээс баталгаат хуулбар авах эрхтэй.

Үүнийг батлан бүрэн эрхт төлөөлөгчид энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Энэхүү конвенцийг 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Гаг хотноо нэг хувь үйлдсэн бөгөөд Нидерландын Засгийн газрын архивт хадгалж, конвенцийн баталгаат хуулбарыг Хэлэлцэн тохиролцогч талд дипломат шугамаар хүргүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

**МОНГОЛ УЛС,  
ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК  
ХООРОНДЫН  
“УЛААНБААТАР ХОТЫН ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫГ БОЛОВСРУУЛАХ  
БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСӨЛ”-ИЙН  
ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР**

**ЭНЭХҮҮ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ, МОНГОЛ УЛС** (цаашид “Зээлдэгч” гэх),  
**ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК** (цаашид “Банк” гэх)  
нарын хооронд 2018 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулав:

### УДИРТГАЛ

Банк нь олон намын тогтолцоот, ардчилсан, олон ургалч үзэлтэй, зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг хэрэгжүүлж буй Төв болон Зүүн Европын орнуудын хувийн хэвшлийн бизнесийн санаачлалыг хөхиүлэн дэмжих, нээлттэй зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцыг дэмжих төслийг хөтөлбөр санхүүжүүлэх зорилготой үүсгэн байгуулагдсан болно. Энэхүү зорилгыг хангах хүрээнд, Банкны шийдвэрийн дагуу Банк нь Өмнөд болон Зүүн Дундад Тэнгисийн гишүүн орнуудад болон Монгол Улсад өөрийн зорилгоо хэрэгжүүлэх боломжтой болохыг **ТЭМДЭГЛЭН**,

Зээлдэгч нь хавсралт 1-д тодорхойлсон Төслийг хэрэгжүүлэх зорилготой бөгөөд (i) хатуу хог хаягдал булж устгах цэг /ландфил/ шинээр барих, түүнтэй холбоотой тоног төхөөрөмжийг худалдан авах, мөн (ii) барилга шинээр барих болон барилга нураалтын хог хаягдлыг боловсруулах



шинэ байгууламжийг Улаанбаатар хотод барих, түүнтэй холбоотой тоног төхөөрөмжийг худалдах авахыг **ТЭМДЭГЛЭН**,

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар (цаашид “Төслийн Хэрэгжүүлэгч” гэх) нь төслийг Зээлдэгчийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхийг **ТЭМДЭГЛЭН**,

Зээлдэгч нь Төслийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх хүсэлтийг Банкнд хүргүүлсэн болохыг **ТЭМДЭГЛЭН**,

Банк нь Төслийн Б хэсгийг хэрэгжүүлэхэд буцалтгүй тусламж хэлбэрээр 1,500,000 (нэг сая таван зуун мянга) евро хүртэлх техникийн хамтын ажиллагааны санхүүжилт олгохыг зөвшөөрснийг **ТЭМДЭГЛЭН**,

Банкийг Үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн 20 дугаар зүйлийн дагуу тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж болох төлөөлөгчийн хэлэлцээр (цаашид “Төлөөлөгчийн хэлэлцээр”)-ийг Банк нь 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Европын Комиссоор төлөөлүүлэн Европын Холбоотой байгуулсан (цаашид “Хандивлагч” гэх) бөгөөд тус хэлэлцээрийн дагуу Банк нь төслийг санхүүжүүлэх хүрээнд санхүүжилтийг удирдах, захиран зарцуулах зорилгоор нээсэн данс (цаашид “Данс” гэх)-нд Хандивлагч нь санхүүжилтийг шилжүүлэх болохыг **ТЭМДЭГЛЭН**,

Банк нь Хандивлагчийн санхүүжилтээс 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянган) еврогийн хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж (цаашид “Буцалтгүй тусламж”)-ийг (дор тодорхойлсон) буцалтгүй тусламжийн хэлэлцээрт тусгасан нөхцөл, болзлын дагуу олгохыг зөвшөөрснийг **ТЭМДЭГЛЭН**,

Банк нь Зээлдэгчид 9,700,000 (есөн сая долоон зуун мянган) ам.долларын үнийн дүн бүхий зээлийн санхүүжилтийг энэхүү хэлэлцээр болон төсөл хэрэгжүүлэгчтэй энэ өдөр байгуулсан төслийн хэлэлцээр (цаашид Стандарт нөхцөл, шаардлагад тодорхойлсны дагуу “Төслийн хэлэлцээр” гэх)-т тусгасан нөхцөл болзлын дагуу олгохыг зөвшөөрснийг **ТЭМДЭГЛЭН**,

**ИЙМД ТАЛУУД** доорх зүйлсийг харилцан тохиролцов. Үүнд:

### **НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ - СТАНДАРТ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА; НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

#### **1.01 дүгээр хэсэг. Стандарт нөхцөл, шаардлагыг хэрэглэх**

Доорх тодруулгаас бусад тохиолдолд Банкны 2012 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Стандарт нөхцөл, шаардлагад тусгасан бүхий л заалтууд



нь энэхүү хэлэлцээрт бүрэн тусгагдан, хүчин төгөлдөр үйлчилж, дагаж мөрдөгдөнө (эдгээр заалт, тодруулгыг цаашид хамтад нь “Стандарт нөхцөл, шаардлага” гэнэ):

(a) Стандарт нөхцөл, шаардлагын 2 дугаар зүйлд тодорхойлсон “Евро”, “EUR” эсхүл “€” гэх тодорхойлолтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

““Евро”, “EUR” эсхүл “€”

гэж Европын Холбооны гишүүн орнуудын хууль ёсны мөнгөн тэмдэгт буюу Европын Холбооны эдийн засаг ба мөнгөний нэгдэлд хамаарах хууль тогтоомжийн дагуу батлагдсан нэг мөнгөн тэмдэгтийг хэлнэ.”

(b) Стандарт нөхцөл, шаардлагын 2.02 дугаар зүйлд тодорхойлсон “албадах”, “үгсэн хуйвалдах” эсхүл “авилга” эсхүл “хуурч мэхлэх” гэх тодорхойлолтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд бүхэлд нь хасч тооцно.

(c) Стандарт нөхцөл, шаардлагын 2.02 дугаар зүйлд тодорхойлсон “Хориотой үйл ажиллагаа” гэх тодорхойлолтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

“Хориотой үйл ажиллагаа” гэж албадах, үгсэн хуйвалдах, авилга, хууран мэхлэх, Банкны санхүүжилтийг буруугаар ашиглах, хүнд суртал эсхүл хулгай зэргийг ойлгох (эдгээр тодорхойлолтыг энэхүү Зээлийн хэлэлцээрийн “Албадан хэрэгжүүлэх бодлого, журам” хэсэгт заасан өдөр баталсан Банкны Албадан хэрэгжүүлэх бодлого, журамд тодорхойлсноор ойлгоно)

(d) Стандарт нөхцөл, шаардлагын 2.02 дугаар зүйлд тодорхойлсон “Лавлах хуудас” гэх тодорхойлолтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

““Лавлах хуудас”

гэж (i) ам.доллар, фунт стерлингээр илэрхийлсэн зээлийн хувьд, Ройтерс-ын мэдээнд LIBOR01 хуудас (эсхүл тухайн Зээлийн валютаар

илэрхийлсэн хадгаламжид санал болгож буй Лондонгийн банк хоорондын ханшийг харуулах, Ройтерс-ын мэдээний LIBOR01 хуудсыг орлох өөр бусад хуудас) гэж тодорхойлсон тухайн зээлийн валютаар илэрхийлсэн хадгаламжид томоохон банкуудын санал болгож буй Лондонгийн банк хоорондын ханшийг харуулсан хуудсыг, (ii) еврогоор илэрхийлсэн зээлийн хувьд, Ройтерс-ын мэдээнд EURIBOR01 хуудас (эсхүл тухайн зээлийн валютаар илэрхийлсэн хадгаламжид санал болгож буй евро бүсийн банк хоорондын ханшийг харуулах, Ройтерс-ын мэдээний EURIBOR01 хуудсыг орлох өөр бусад хуудас) гэж тодорхойлсон тухайн зээлийн валютаар илэрхийлсэн хадгаламжид томоохон банкуудын санал болгож буй евро бүсийн банк хоорондын ханшийг харуулсан хуудсыг тус тус хэлнэ.

(e) Стандарт нөхцөл, шаардлагын 2.02 дугаар зүйлд тодорхойлсон “ТАРГЕТ өдөр” гэх тодорхойлолтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

“ТАРГЕТ системийн ажлын өдөр”

Транс-Европын автоматжуулсан бодит цагийн нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем еврогийн төлбөр тооцоог гүйцэтгэхээр нээлттэй байх өдрийг хэлнэ.

(f) Стандарт нөхцөл, шаардлагын 3.04(a) дугаар зүйлийг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

“(a) Хэрэв зээл нь хувьсагч хүүгийн ханшийг мөрдөж байгаа тохиолдолд доорх 3.04(b) хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох зах зээлийн хүүгийн ханшийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:



(i) Зээл татан авалт бүрийн эхний хүү тооцох хугацааны хувьд, тухайн хүү тооцох хугацааны үргэлжлэх хугацаатай тэнцүү хугацаанд хамаарах хүү тодорхойлох өдрийн өглөөний 11.00 цагийн (ам.доллар, фунт стерлингийн хувьд Лондонгийн цагаар, еврогийн хувьд Брюсселлийн цагаар) байдлаар лавлах хуудсаар харуулсан, зээлийн валютаар илэрхийлсэн хадгаламжид санал болгосон жилийн ханшийг баримтална. Хэрэв тухайн хүү тооцох хугацааны үргэлжлэх хугацаатай тэнцүү хугацаанд хамаарах ийм ханш лавлах хуудаст харуулаагүй боловч тухайн хүү тооцох хугацааны үргэлжлэх хугацаанаас богино ба урт хугацаа аль алинд хамаарах ханшууд лавлах хуудаст харуулсан тохиолдолд («лавлах хувиуд») лавлах хуудаст нэг талаас тухайн хүү тооцох хугацааны хугацаанаас дараагийн богино хугацаанд, нөгөө талаас тухайн хүү тооцох хугацааны хугацаанаас дараагийн урт хугацаанд тус тус хамаарах лавлах ханшуудад тулгуурлаж шулуун шугамын интерполяцийн аргаар тооцсон, тухайн хүү тооцох хугацааны үргэлжлэх хугацаатай тэнцүү хугацаанд хамаарах ханшийг (шаардлагатай бол их тоо руу бүхэлдүүлэх ба аравтын дөрвөн оронгоос үл хэтрүүлнэ) холбогдох зах зээлийн ханшийг тооцно; мөн

(i) дараа дараагийн хүү тооцох хугацааны хувьд, тухайн хүү тооцох хугацааны үргэлжлэх хугацаатай хамгийн их дүйцэж тэнцэх хугацаанд хамаарах хүү тодорхойлох өдрийн өглөөний 11.00 цагийн (ам.доллар, фунт стерлингийн хувьд Лондонгийн цагаар, еврогийн хувьд Брюсселлийн цагаар) байдлаар лавлах хуудсаар харуулсан, зээлийн валютаар илэрхийлсэн хадгаламжид санал болгосон жилийн ханшийг баримтална (хэрэв хоёр тусдаа хугацаа тухайн хүү тооцох хугацааны үргэлжлэх хугацаатай хоёулаа адил хэмжээгээр дүйцэж тэнцэх тохиолдолд тухайн хоёр хувийн дунджийг баримтална).

Дээрх тохиолдлуудад дараах нөхцөл хангагдсан байна. Үүнд:

(1) Хэрэв лавлах хуудсыг ашиглан холбогдох зах зээлийн хүүгийн ханшийг аливаа шалтгааны улмаас тодорхойлох боломжгүй бол тухайн хүү тооцох



хугацааны мөчлөгт хувьсагч хүүгийн ханшаар эргэн төлөгдөх хуваарь бүхий зээлтэй тэнцүү хэмжээтэй, зээлийн валютаар илэрхийлсэн, тухайн хүү тооцох хугацаатай тэнцүү хугацаа бүхий хадгаламжийн хувьд Лондонгийн банк хоорондын зах зээл (ам.доллар, фунт стерлингийн хувьд), эсхүл евро бүсийн банк хоорондын зах зээлд (еврогийн хувьд) идэвхтэй оролцдог, Банкны өөрийн сонгосон, 2-оос доошгүй томоохон банкны зүгээс Лондонгийн банк хоорондын зах зээл (ам.доллар, фунт стерлингийн хувьд), эсхүл евро бүсийн банк хоорондын зах зээл (еврогийн хувьд) дээрх тэргүүлэх банкнуудад санал болгосон жилийн хэд хэдэн ханшийн дунджийг холбогдох зах зээлийн хүүгийн хувьд тооцно (шаардлагатай бол их тоонд бүхэлдүүлэх ба аравтын дөрвөн оронгоос үл хэтрүүлнэ).

- (2) Хэрэв энэхүү 3.04(а) дугаар зүйлд заасны дагуу холбогдох зах зээлийн хүүгийн ханшийн дундаж нь тэгээс бага бол холбогдох зах зээлийн хүүгийн хэмжээг тэгтэй тэнцүү гэж үзнэ.

(g) Стандарт нөхцөл, шаардлагын 3.04(е) заалтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

“(е) Стандарт нөхцөл, шаардлагын 7.06 дугаар хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд үргэлжилсээр байгаа тохиолдолд Банк зээлд хамаарах хүүг төлөхийг Зээлдэгчээс шаардаж болох бөгөөд энэ тохиолдолд тогтмол хүүгийн ханштай бол тогтмол хүүгийн ханш бус, харин хувьсах хүүгийн ханш тооцно.”

(h) Стандарт нөхцөл, шаардлагын 3.09(а)(iii) заалтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар ойлгоно. Үүнд: “(iii) хугацаа хэтэрсэн зээлийн дүнтэй ойролцоо дүн бүхий, зээлийн валютаар илэрхийлсэн, хугацаа хэтрүүлсний хүүг тооцох хугацаатай тэнцүү хугацаа бүхий хадгаламжийн хувьд Лондонгийн банк хоорондын зах зээлд (ам.доллар, эсхүл фунт стерлингийн хувьд), эсхүл евро бүсийн банк хоорондын зах зээлд (еврогийн хувьд) хугацаа хэтрүүлсний хүүг тодорхойлох өдрийн байдлаар мөрдөж буй жилийн хүүгийн ханш, эсхүл зах зээл тогтворгүйжих үйл



явдал бий болсон тохиолдолд банкны өөрийн сонгосон эх сурвалжаас зээлийг санхүүжүүлэхээр татсан эх үүсвэрийн өртгийг жилээр хувьчилж илэрхийлсэн ханш (эсхүл холбогдох зах зээлийн хүүгийн ханшийг баримтлахаар банк өөрөө шийдвэрлэсэн бол уг ханш), энэхүү (iii) дэд хэсгийн дагуу тодорхойлсон ханш нь тэгээс бага тохиолдолд тэг гэж тооцно.

(i) Стандарт нөхцөл, шаардлагын 3.10(b)(2) заалтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар ойлгоно. Үүнд: “Тогтмол хүүгийн ханшаар хүү тооцох зээлийн аль нэг хэсгийг 7.06 дугаар хэсэгт заасны дагуу хугацааг нь урагшлуулж төлүүлэх болсон, эсхүл бусад байдлаар зээлийн хэлэлцээрт заасан хугацаанаас нь өмнө төлсөн, эсхүл Стандарт нөхцөл, шаардлагын 3.04(e) заалтад заасны дагуу хувьсагч хүүгийн ханштай болсон бол; эсхүл”

(j) Стандарт нөхцөл, шаардлагын 3.13(a)(1)(B) заалтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар ойлгоно. Үүнд: “(B) Банкны өөрийн сонгосон эх сурвалжаас зээлийг санхүүжүүлэхээр татсан эх үүсвэрийн өртгийг жилээр хувьчилж илэрхийлсэн ханш (эсхүл холбогдох зах зээлийн хүүгийн ханшийг баримтлахаар банк өөрөө шийдвэрлэсэн бол уг ханш) ба үүнийг Банкнаас Зээлдэгчид нэн яаралтай, гэхдээ ямар ч тохиолдолд тухайн хүү тооцох хугацаанд ногдох хүү төлөх өдрөөс өмнө мэдэгдвэл зохих бөгөөд энэхүү (B) хэсэгт заасан ханш нь тэгээс доош хэмжээтэй байх нөхцөлд ханшийг тэгтэй тэнцүү хэмжээтэй гэж тооцно; мөн”

(k) Стандарт нөхцөл, шаардлагын 4.04(a)(ii) заалтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

“(ii) Банкны хүсэлтээр Банкны төлөөлөгч нарт дараах нөхцөлийг хангана. Үүнд:

(A) Төслийн барилга байгууламж, барилгын талбайд нэвтрэх, барилгын явцтай танилцах;

(B) Зээлийн хөрөнгөөр санхүүжих аливаа бараа, ажил, үйлчилгээ, түүнчлэн зээлдэгчийн зээлийн хэлэлцээрт заасан үүргийн биелэлттэй холбоотой аливаа үйлдвэр, барилга байгууламж, барилгын талбай, ажил, үйлчилгээ, тоног төхөөрөмж, баримт бичиг, тайлан бүртгэлтэй тус тус үзэж танилцах”;

(C) Дээрх зорилгоор, хэрэв Банк шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зээлдэгчийн тухайн ажилтан, төлөөлөгч нартай уулзах, хэлэлцээ хийх,

аль ч тохиолдолд, дээрх боломжууд нь (i) Банк төслийг үнэлэхэд хөнгөвчлөх зорилготой, Банкны Төслийн гомдол гаргах, хэлэлцэх журмын дагуу гаргасан төсөлтэй холбоотой аливаа гомдлыг шалгах, шийдвэрлэх боломжоор хангах, мөн (ii) Төсөл буюу энэхүү хэлэлцээрт заасан хэлцэлтэй холбоотойгоор хориотой үйл ажиллагаа үүссэн эсэхийг үнэлэхэд чиглэнэ.”



(l) Стандарт нөхцөл, шаардлагын 8.01 хэсэгт энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар ойлгоно. Үүнд:

“Энэхүү Стандарт нөхцөл, шаардлага, Зээлийн хэлэлцээр, Баталгааны хэлэлцээр, эсхүл Төслийн хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хориотой үйл ажиллагааг эрхлэн явуулсан гэж үзэх үндэслэл байвал Банк нь Албадан хэрэгжүүлэх бодлого, журмыг хэрэгжүүлэх эрх бүхий болохыг Зээлдэгч, Батлан даагч болон Төсөл хэрэгжүүлэгч (Төсөл хэрэгжүүлэгч байгаа тохиолдолд) нар нь хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.”

(m) Стандарт нөхцөл, шаардлагын 8.04(b)(iii) заалтыг энэхүү хэлэлцээрийн хүрээнд дараах байдлаар ойлгоно. Үүнд: “(iii) Арбитрын Байнгын Шүүхийн Ерөнхий нарийн бичгийн дарга арбитрчдыг томилох тохиолдолд тэрбээр арбитрчийн шаардлагыг хангах аливаа этгээдийг Олон улсын Худалдааны Хуулийн НҮБ-ын Комиссын Арбитрын дүрмийн 9.2, эсхүл/болон 9.3 дугаар зүйлийн дагуу томилох эрхтэй”.

### 1.02 дугаар хэсэг. Нэр томьёоны тодорхойлолт

Хэрэв хэлэлцээрт өөрөөр заагаагүй эсхүл агуулгын хувьд өөрөөр тусгагдаагүй тохиолдолд энэхүү хэлэлцээрийн удиртгал болон хавсралтад заасан нэр томьёог түүнд харгалзах утгаар, Стандарт нөхцөл, шаардлагад заасан нэр томьёог түүнд харгалзах утгаар тус тус ойлгох ба дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Зээлдэгчийн эрх бүхий төлөөлөгч”

гэж Зээлдэгчийн Сангийн дэд сайдыг хэлнэ.

“КлайнтНет”

гэж Банк болон түүний үйлчлүүлэгчийн хооронд мэдээлэл солилцох зориулалт бүхий Банкны цахим сүлжээ ба Банкны зүгээс Зээлдэгчид тухай бүр мэдэгдсэн, өөрчлөгдсөн цахим хуудсыг хэлнэ.

“Албадан хэрэгжүүлэх бодлого, журам”

гэж Банкны 2017 оны 10-р сарын 04-ний өдөр баталсан Албадан хэрэгжүүлэх бодлого, журмыг хэлнэ.

“Байгаль орчинд Нөлөөлөх үнэлгээ/ амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөө” буюу «БОНУ/АОСТ»

гэж ЕХ АХОС-ын чиглэл (85/337/ЕЕС)-д заасны дагуу ТХА буцалтгүй



тусламжаар санхүүжих байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олон улсын зөвлөхийн бэлтгэх хөтөлбөр, уг хөтөлбөрөөр хог хаягдал цуглуулагч нарын амьжиргааны суурь нөхцөлийг тодорхойлж, зөвлөгөө үзүүлэх болно.

“Санхүүгийн жил»

гэж жил бүрийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэх Зээлдэгчийн санхүүгийн жилийг хэлнэ.

“ТХН”

гэж Төсөл хэрэгжүүлэгчийн байгуулсан, төслийг удирдаж, гүйцэтгэх чиг үүрэг бүхий төсөл хэрэгжүүлэх нэгж ба нэгж нь Банкны шаардлагад нийцэхүйц хэмжээнд байгуулагдаж, ажиллах хүчээр хангагдаж, үйл ажиллагаагаа явуулна.

“Дэд хэлэлцээр”

гэж 3.01(а) заалтад заасны дагуу Төсөл хэрэгжүүлэгч ба Зээлдэгч нарын хооронд тохиролцож, байгуулсан хэлэлцээр буюу түүнд тухай бүр орсон аливаа нэмэлт өөрчлөлтийг хэлнэ.

### **1.03 дугаар хэсэг. Тайлбар**

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй аливаа зүйл, хэсэг эсхүл хавсралтыг энэхүү хэлэлцээрийн зүйл, хэсэг, хавсралт гэж ойлгоно.

## **ХОЁРДУГААР ЗҮЙЛ - ЗЭЭЛИЙН ҮНДСЭН НӨХЦӨЛ**

### **2.01 дүгээр хэсэг. Мөнгөн дүн ба валют**

Банк нь энэхүү хэлэлцээрт заасан нөхцөл болзлын дагуу 9,700,000 ам.долларын санхүүжилтийг Зээлдэгчид зээлдүүлэхийг зөвшөөрсөн болно.

### **2.02 дугаар хэсэг. Зээлийн бусад санхүүгийн нөхцөл**

(а) Татан авалтын доод хэмжээ 250,000 ам.доллар байна.

(б) Хугацаанаас өмнө төлөх зээлийн доод хэмжээ 2,000,000 ам.доллар байна.

(с) Зээл цуцлах доод хэмжээ 500,000 ам.доллар байна.

(d) Хүү төлөх өдөр нь жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны өдөр болон 3 дугаар сарын 20-ны өдрүүд байна.

(е) (1) Зээлдэгч нь хагас жил тутамд жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны өдөр болон 3 дугаар сарын 20-ны өдөр, зээлийг 24 тэнцүү хэмжээний (эсхүл аль болох тэнцүү хэмжээнд ойролцоо) төлбөрөөр эргэн төлөх бөгөөд анхны зээл эргэн төлөх өдөр нь 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр байх ба сүүлчийн зээл эргэн төлөх өдөр нь 2033 оны 3 дугаар сарын 20-ны өдөр тус тус байна.

(2) Дээр заасныг үл харгалзан, хэрэв (i) Зээлдэгч нь 2.02(е) хэсэгт заасны дагуу зээлийг анхны зээл эргэн төлөх өдрөөс өмнө зээл татан авалт хийгээгүй, болон (ii) Банк нь доорх 2.02.(f) хэсэгт заасан зээл олгох сүүлчийн өдрийг тухайн хугацаа хэтэрсэн анхны зээл эргэн төлөх өдрөөс хойш аль нэг өдөр болгон сунгахыг зөвшөөрсөн бол анхны зээл эргэн төлөх өдрөөс хойш хийгдсэн татан авалт бүрийг ийнхүү татан авснаас хойших зээлийн эргэн төлөх өдрүүдэд тэнцүү хэмжээгээр эргэн төлөхөөр ногдуулж хуваарилна (аль ч тохиолдолд ийнхүү хуваарилах тухайн дүнг бүхэлдүүлэх шаардлагатай бол банк ийнхүү бүхэлдүүлж болно). Банк нь ийнхүү хуваарилсан талаар Зээлдэгчид тухай бүр мэдэгдэнэ.

(f) Зээл олгох сүүлчийн өдөр нь энэхүү хэлэлцээрийг байгуулснаас хойш 3 жил өнгөрсний дараах өдөр, эсхүл Банк өөрийн санаачилгаар үүнээс хойших өөр нэг өдрийг сонгож, Зээлдэгч болон Батлан даагч нарт мэдэгдсэн өдөр байна. Хэрэв боломжит үлдэгдэлд (эсхүл үүний зарим хэсэгт) тогтмол хүүгийн ханшинд хамаарах ба Банк зээл олгох сүүлчийн өдрийг хойшлуулахыг зөвшөөрсөн тохиолдолд Зээлдэгч нь Банкнаас тухай бүр өөрт нь бичгээр ирүүлсэн мэдэгдэлд тусгасан зээлийн нөхцөлийн өөрчлөлттэй холбоотой зардлыг Банкинд нэн даруй төлнө.

(g) Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр нь жилийн 0.5 хувь байна.

(h) Зээлд хувьсагч хүүгийн ханш тооцно. Дээр өөрөөр заагаагүй тохиолдолд Зээлдэгч нь Стандарт нөхцөл, шаардлагын 3.04 (с) хэсэгт заасны дагуу зээлийн бүх, эсхүл зарим хэсэгт хувьсах хүүгийн ханшийн оронд тогтмол хүүгийн ханш бүхий хүүг төлөх сонголтыг хийж болно.

### **2.03 дугаар хэсэг. Зээл татан авалт**

Зээлдэгч хавсралт 2-т заасны дагуу (1) Төсөлд шаардагдах (эсхүл Банк зөвшөөрсөн бол) бараа, ажил, үйлчилгээнд хамаарах зардал, зарцуулалтыг мөн (2) Зээл олгосны шимтгэлийг тус тус санхүүжүүлэх зорилгоор боломжит үлдэгдлийг тухай бүр татан авч болно.



## ГУРАВДУГААР ЗҮЙЛ - ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ

### 3.01 дүгээр хэсэг. Төслийн бусад үүрэг

Банк өөрөөр заагаагүй бол Стандарт нөхцөл, шаардлагын IV болон V дугаар зүйлд заасан ерөнхий үүргүүдээс гадна Зээлдэгч нь дараах бусад үүргийг хүлээнэ. Үүнд:

(a) Банкны шаардлагад нийцсэн Дэд хэлэлцээрийг Төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулж, Банк зөвшөөрч болохуйц нөхцөл, журмаар зээл болон буцалтгүй тусламжийг түүнд олгоно.

(b) Банк болон Зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах, энэхүү хэлэлцээрт заасан зохицуулалтыг хангах, мөн зээл болон буцалтгүй тусламжийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах;

(c) Банк зөвшөөрснөөс бусад тохиолдолд Дэд хэлэлцээрээр хүлээсэн аливаа эрх, үүргээ бусдад шилжүүлэхгүй, хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулахгүй, хэлэлцээрийг цуцлахгүй, хэлэлцээрт заасан эрхээсээ татгалзахгүй;

(d) Төсөл хэрэгжүүлэгч төслийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүргийг хангах;

(e) Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг гаргахад чиглэсэн бүхий л нэмэлт арга хэмжээг авах, эсхүл арга хэмжээг авахуулах;

(f) Төслийн хүрээнд Банкаас олгосон зээл, буцалтгүй тусламж эсхүл бусад техникийн хамтын ажиллагааны санхүүжилтээр Төсөл хэрэгжүүлэгчийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ (үүнд зөвлөх үйлчилгээг багтана)-г татвар (НӨАТ багтана) болон хураамж (гаалийн хураамж багтана)-аас чөлөөлөх, эсхүл тэдгээрийг нөхөн төлөх.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ - ТҮДГЭЛЗҮҮЛЭХ; ТҮРГЭСГЭХ; ЦУЦЛАХ

### 4.01 дүгээр хэсэг. Түдгэлзүүлэх

Стандарт нөхцөл, шаардлагын 7.01(a)(xvii) заалтын хүрээнд дараах нэмэлт үндэслэлийг тусгайлан заав. Үүнд:

(a) Банк бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Зээлдэгчийн нутаг дэвсгэр дахь хатуу хог хаягдлын удирдлагатай холбоотой хууль тогтоомж өөрчлөгдсөн, түдгэлзсэн, цуцлагдсан, хүчингүй болсон, эсхүл тэдгээрийн үйлчлэлээс татгалзсан;



(b) Үүсгэн байгуулах хэлэлцээр өөрчлөгдсөн, түдгэлзсэн, цуцлагдсан, хүчингүй болсон, эсхүл тэдгээрийн үйлчлэлээс татгалзсан;

(c) Төсөл хэрэгжүүлэгч нь Дэд хэлэлцээрт хүлээсэн үүргээ зөрчсөн;

(d) Буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн 6.01 дүгээр хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн.

#### **4.02 дугаар хэсэг. Зээлийн эргэн төлөх хугацааг урагшлуулах**

Стандарт нөхцөл, шаардлагын 7.06(f) заалтын хүрээнд дараах нэмэлт нөхцөлийг тусгайлан заав. Үүнд:

(a) 4.01 дүгээр хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн.

### **ТАВДУГААР ЗҮЙЛ - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

#### **5.01 дүгээр хэсэг. Хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөл**

Стандарт нөхцөл, шаардлагын 9.02(c) хэсгийн хүрээнд, энэхүү хэлэлцээр болон Төслийн хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох нэмэлт урьдчилсан нөхцөлүүдийг тусгайлан заав. Үүнд:

(a) Дэд хэлэлцээрийг Банкны шаардлагад нийцүүлэн байгуулж, Банкинд хүргүүлсэн бөгөөд уг Дэд хэлэлцээр, түүнд заасан Төсөл хэрэгжүүлэгчийн зээлийн татан авалт хийх эрх тус тус хүчин төгөлдөр болох бүхий л урьдчилсан нөхцөлүүд (энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдлаас бусад) мөн бүрэн хангагдсан байна;

(b) ТХН нь зохих ёсоор үүсгэн байгуулагдсан байх бөгөөд зохих ёсоор ажиллах хүч, хангалттай эх үүсвэр, төслийн удирдлага болон олон улсын худалдан авах ажиллагааны мэргэшилтэй байх;

(c) ТХН-ийн зөвлөхүүд нь Банкны шаардлагад нийцсэн байх бөгөөд Төсөл хэрэгжүүлэгчтэй хэлэлцээр байгуулсан байна; мөн

(d) Төсөл хэрэгжүүлэгч нь БОНУ/АОСТ-ийг Банкны шаардлагад нийцүүлэн боловсруулж баталсан байх бөгөөд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар, эсхүл түүний залгамжлагч яамаар батлуулсан байна.

#### **5.02 дугаар хэсэг. Хууль зүйн дүгнэлт**

(a) Стандарт нөхцөл, шаардлагын 9.03(a) хэсгийн хүрээнд, Зээлдэгчийн хуулийн зөвлөх болох Хууль зүй, дотоод хэргийн сайд, эсхүл түүний



залгамжлагч хууль зүйн дүгнэлт (эсхүл дүгнэлтүүд)-ийг гаргаж, Банкинд хүргүүлэх ба уг хууль зүйн дүгнэлтэд доорх нэмэлт зүйлсийг тусгасан байна. Үүнд:

(1) Зээлдэгчийг төлөөлж, түүний өмнөөс эрх бүхий этгээд Дэд хэлэлцээр болон Буцалтгүй тусламжийн хэлэлцээрийг байгуулж, нөгөө талд хүргүүлсэн, түүнчлэн Дэд хэлэлцээр болон Буцалтгүй тусламжийн хэлэлцээр нь хүчин төгөлдөр, заавал биелүүлэх, түүнд заасны дагуу албадан биелүүлэх Зээлдэгчийн үүрэг мөн болохыг.

(b) Стандарт нөхцөл, шаардлагын 9.03(c) хэсгийн хүрээнд, Төсөл хэрэгжүүлэгчийн дотоодын зөвлөхөөс хууль зүйн дүгнэлт (эсхүл дүгнэлтүүд)-ийг гаргаж, Банкинд хүргүүлэх ба уг хууль зүйн дүгнэлтэд доорх нэмэлт зүйлсийг тусгасан байна. Үүнд:

(1) Төсөл хэрэгжүүлэгчийг төлөөлж, түүний өмнөөс эрх бүхий этгээд Дэд хэлэлцээрийг байгуулж, нөгөө талд хүргүүлсэн, түүнчлэн Дэд хэлэлцээр нь хүчин төгөлдөр, заавал биелэх, түүнд заасны дагуу албадан биелүүлэх Төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг мөн болохыг.

### **5.03 дугаар хэсэг. Хүчин төгөлдөр болоогүйн улмаас хэлэлцээрийг дуусгавар болгох**

Стандарт нөхцөл, шаардлагын 9.04 дүгээр хэсэгт зориулж энэхүү хэлэлцээрийг байгуулсан өдрөөс хойш 180 хоног болохыг тусгайлан заав.

## **ЗУРГААДУГААР ЗҮЙЛ - БУСАД ЗҮЙЛС**

### **6.01. дүгээр хэсэг. Мэдэгдэл**

(a) Стандарт нөхцөл, шаардлагын 10.01 дүгээр хэсгийн хүрээнд доорх зүйлсийг тусгайлан заав. Үүнд:

Зээлдэгчийн хувьд:

Сангийн Яам  
Засгийн газрын 2 дугаар байр,  
Данзангийн гудамж 5/1  
Улаанбаатар 15160, Монгол Улс

Хэнд: Хөгжлийн санхүүжилтийн газарт  
Факс: 976-51-267468



Банкны хувьд:

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк  
Ван Эксчэйнж Скүэр  
Лондон EC2A 2JN  
ИБУИВУлс

Хэнд: Үйл ажиллагаа захиргааны нэгж  
Факс: +44-20-7338-6100

(b) Банк нь Зээлдэгчийг КлайнтНет эсхүл бусад цахим харилцаа холбооны хэлбэрийг хэрэглэхийг санал болгож болох ба хэрэв Зээлдэгч болон Банк нар нь КлайнтНет эсхүл бусад цахим харилцааны хэлбэрийг хэрэглэхээр тохирсон тохиолдолд Зээлдэгчээс Банкинд эсхүл Банкнаас Зээлдэгчид ирүүлэх аливаа мэдэгдэл, өргөдөл эсхүл харилцаа холбоог (энэхүү Хэлэлцээр эсхүл Буцалтгүй тусламжийн хэлэлцээрээр эх хувиараа, гэрчлэгдсэн хуулбараар эсхүл цаасаар байхаар шаардсан мэдэгдэл, өргөдөл эсхүл харилцаа холбооноос бусад тохиолдолд) нь КлайнтНет эсхүл тухайн харилцаа холбооны бусад хэлбэрийн нөхцөл, болзлын хүрээнд, КлайнтНетэд тухайн мэдэгдэл, өргөдөл эсхүл харилцаа холбоог байршуулж эсхүл тухайн харилцаа холбооны бусад хэлбэртэй холбоотойгоор тохиролцсон нөхцөлийн дагуу илгээж болно.

(c) Биечлэн, агаарын шуудангаар, факсаар эсхүл КлайнтНет буюу цахим харилцаа холбооны бусад хэлбэрээр хүргэсэн аливаа мэдэгдэл, өргөдөл буюу харилцаа холбоо нь зөвхөн унших боломжтой байдлаар, бодитоор хүлээн авсан (эсхүл боломжтой болсон) тохиолдолд хүчинтэйд тооцогдоно. Энэ тохиолдолд тухайн мэдэгдэл, өргөдөл эсхүл харилцаа холбоог үдээс хойш 5:00 цагаас хойш, тухайн мэдэгдэл, өргөдөл эсхүл харилцаа холбоог хүлээн авах талын энэхүү Хэлэлцээрт заасан хаягт хүргүүлсэн (боломжтой болсон) тохиолдолд тэдгээрийг дараагийн өдрөөс хүчин төгөлдөр болно гэж үзнэ.

(d) Доорх хэсэгт Банкнаас КлайнтНеттэй холбогдуулан аливаа урилга явуулах зорилгоор холбогдохоор эхний ээлжид томилогдсон Зээлдэгчийн холбоо барих этгээдийн нэр, албан тушаал, и-мэйл хаягуудыг оруулав.

Үүнд:

<i>Нэр</i>	<i>Албан тушаал</i>	<i>И-мэйл хаяг</i>
Батхүү Идэш	Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга	Batkhuu_i@mof.gov.mn
Энхцацрал Намхайжанцан	Хөгжлийн санхүүжилтийн газрын мэргэжилтэн	Enkhtsatsral_n@mof.gov.mn



**ДЭЭР ДУРДСАНЫГ ГЭРЧЛЭН**, энэхүү хэлэлцээрийг талууд тус бүрийн эрх бүхий этгээдүүдээр төлөөлүүлэн, дээр дурдсан өдөр Йорданы Хашемын Хаант улсын нийслэл Амман хотноо дөрвөн хувь байгуулав.

**МОНГОЛ УЛС:**

Гарын үсэг: \_\_\_\_\_  
Нэр: Булгантуяа Хүрэлбаатар  
Албан тушаал: Сангийн дэд сайд

**ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК:**

Гарын үсэг: \_\_\_\_\_  
Нэр: Жүрген Ригтершик  
Албан тушаал: Тэргүүн дэд ерөнхийлөгч

## ХАВСРАЛТ 1 - ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Төслийн зорилго нь Төсөл хэрэгжүүлэгчийн байгуулж буй (i) хатуу хог булшлах цэг /ландфил/ шинээр барих, түүнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах мөн (ii) шинэ барилга барих болон барилга нураалтын хог хаягдлын байгууламж барих, түүнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах.

2. Банк болон Зээлдэгч нар өөрөөр тохироогүй бол Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

### А хэсэг - Хөрөнгийн зардлууд

- Хатуу хог хаягдал булж устгах цэг шинээр /ландфил/ барих
- Булж устгах цэг /ландфил/-ийн үйл ажиллагааны тоног төхөөрөмж
- Шинэ барилга барих болон барилга нураалтын хог хаягдал боловсруулах байгууламж
- Шинэ барилга барих болон барилгын устгалын хог хаягдал боловсруулах байгууламжийн үйл ажиллагааны тоног төхөөрөмж

### Б хэсэг - Техникийн хамтын ажиллагаа

- Төсөл хэрэгжүүлэх дэмжлэг
- Хатуу хог хаягдлын салбарын хөгжил ба байгууллагын чадавх бэхжүүлэх
- Хотын Өрийн Удирдлагын Хөтөлбөр; болон
- Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ (БОНҮ)/Амьжиргааг дэмжих хөтөлбөр (АДХ);
- Ногоон Хотын Үйл Ажиллагааны Төлөвлөгөө (НХҮАТ)

3. Төслийг энэхүү хэлэлцээрийг байгуулснаас хойш 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж байна.



## ХАВСРАЛТ 2 - ЗАРДЛЫН АНГИЛАЛ БА ЗЭЭЛ ТАТАН АВАЛТ

1. Энэхүү хавсралтад зардлын ангиллыг хүснэгтээр хавсаргав. Зээлийн хэмжээг ангилал тус бүрт заасан ба зардлын ангилал тус бүрээр санхүүжих зардлын хувийг тусгасан болно.
2. Дээрх 1 дүгээр зүйлд зааснаас үл хамааран, зээлийн хэлэлцээрийг байгуулсан өдрөөс өмнө гарсан аливаа зардалд зээл татан авалт хийхгүй.

### Хавсралт 2-ийн Хүснэгт

Зардлын ангилал	Зээлийн валютаар олгох зээлийн дүн	Зардлыг санхүүжүүлэх хувь хэмжээ
(1) Төслийн А хэсэгт хамаарах бараа, ажил, үйлчилгээ	9,603,000 ам.доллар	Татвар тооцохгүйгээр хэлэлцээрийн үнийн дүнгийн 100% хүртэл
(2) Зээл олгосны шимтгэл	97,000 ам.доллар	100%
<b>Нийт</b>	<b>9,700,000 ам.доллар</b>	

**Хаяг:**  
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)  
**Утас:** 262420  
Хэвлэлийн хуудас: 4.25  
**Индекс: 200003**